



НҮБ-ЫН ХҮНИЙ  
ЭРХИЙН ДЭЭД  
КОМИССАРЫН ГАЗАР

НҮБ  ХАБИТАТ

# ШААРДЛАГАД НИЙЦСЭН ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХ

Х  
У  
Н  
И  
Й  
Э  
Р  
Х



НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ  
БАЙГУУЛЛАГА

УИНМН  
СУДАЛГААНЫ  
САН

Мэргэжлийн  
гарын авлага

**№21**

(шинэчилсэн  
товхимол 1)



Нээлтэй Нийгэм Форумын дэмжлэгтэйгээр “Иргэдийн эрх зүйн чадавхыг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд Монголын Эмнести Интернэшнлийн “Төр үүргээ мэд, биелүүл” кампанит ажлын “Орон байртай байх эрх-Эрх зүйн хөтөч” төслөөс 2000 ширхэг хэвлүүлэв.

Энэ гарын авлагыг Монголын Эмнести Интернэшнлээс үнэгүй авч болно.

2019 он

**Утас/Факс:** 976-70004705, 70004708

**Цахим шуудан:** [mongolia.amnesty@gmail.com](mailto:mongolia.amnesty@gmail.com)

**Цахим хуудас:** [www.amnesty.mn](http://www.amnesty.mn)



Amnesty International Mongolia-Монголын  
Эмнести Интернэшнл

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН



НҮБ-ын Хүний Эрхийн  
Дээд Комиссарын Газар

НҮБ  ХАБИТАТ

НҮБ-ын Хүн Амын нутагшил,  
суурьшлын хөтөлбөр  
/ХАБИТАТ/

# ШААРДЛАГАД НИЙЦСЭН ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХ

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

## ТЭМДЭГЛЭХ НЬ

Энэхүү хэвлэл болон түүнд ашигласан материал нь аливаа улс орон, нутаг дэвсгэр, хот суурин, тэдгээрийн удирдлагын эрх зүйн байдал болон хил хязгаарын талаар НҮБ-ын Нарийн Бичгийн Дарга Нарын Газрын зүгээс ямар нэгэн үзэл бодол илэрхийлээгүй болно.

\*  
\* \*

Уг хэвлэлд дурьдагдсан материалыг чөлөөтэй иш татан ашиглаж, дахин хэвлэж болох бөгөөд дахин хэвлэсэн материалын хувийг НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын Газрын хаягаар илгээнэ үү.  
Хаяг: Palais des Nations, 8-14 avenue de law Paix, CH-1211 Geneva 10, Switzerland

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

## АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР .....	IV
ТАНИЛЦУУЛГА .....	V
I. ШААРДЛАГАД НИЙЦСЭН ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХ ГЭЖ ЮУ ВЭ? .....	1
А. Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн талаарх үндсэн ухагдахуун .....	1
Б. Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн талаарх ташаа ойлголтууд .....	5
В. Шаардлагад нийцсэн орон байртай байх эрх ба хүний бусад эрхийн харилцан хамаарал .....	9
Г. Үл ялгаварлах зарчмыг хэрхэн хэрэглэх вэ? .....	10
Д. Хүний эрхийн олон улсын хэм хэмжээгээр шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хамгаалсан нь .....	11
II. ШААРДЛАГАД НИЙЦСЭН ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХИЙГ НИЙГМИЙН ТОДОРХОЙ БҮЛГИЙН ЭРХ АШИГТ НИЙЦҮҮЛЭН ХЭРХЭН ХЭРЭГЛЭХ ВЭ? .....	17
А. Эмэгтэйчүүд .....	17
Б. Хүүхэд .....	21
В. Ядуусын хорооллын оршин суугчид .....	23
Г. Орон гэргүй хүмүүс .....	24
Д. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд .....	26
Е. Шилжин суурьшигч болон цагаачид .....	29
Ё. Уугуул иргэд .....	32
III. УЛС ОРНУУД БОЛОН ХОЛБОГДОХ БУСАД ТАЛУУДЫН ҮҮРЭГ .....	35
А. Нийтлэг үүрэг .....	35
Б. Үүргийн гурван төрөл .....	38
В. Бусад этгээдийн үүрэг .....	40

IV. ШААРДЛАГАД НИЙЦСЭН ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ, УЛС ОРНУУДАД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА .....	44
А. Үндэсний түвшний хяналт, хариуцлага .....	44
Б. Бүс нутгийн түвшинд хүлээх хариуцлага .....	50
В. Олон улсын түвшний хяналт .....	51
<i>Хавсралт:</i> Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхтэй холбоотой олон улсын баримт бичгүүд .....	56

### ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ДД (IDPs)	Дотоодын шилжин суурьшигч
ОУХБ (ILO)	Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага
ТББ (NGOs)	Төрийн бус байгууллага
ХЭҮБ (NHRI)	Хүний эрхийн үндэсний байгууллага
НҮБ-ын ХЭДКГ (ОНСНР)	НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын Газар
НҮБ-Хабитат (UN-Habitat)	НҮБ-ын Хүн амын нутагшил, суурьшлын Хөтөлбөр
НҮБ-ын ОББЭХ (UNHRP)	НҮБ-ын Орон байртай байх Эрхийн Хөтөлбөр
ЮНИСЕФ (UNICEF)	НҮБ-ын Хүүхдийн сан

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

## ТАНИЛЦУУЛГА

Олон улсын хүний эрхийн хэм хэмжээгээр хүн бүрийн шаардлагад нийцсэн орон сууцыг оролцуулаад амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх эрхийг баталгаажуулсан билээ. Хэдийгээр дээрх эрх нь олон улсын эрх зүйн тогтолцоонд чухал байр суурь эзэлдэг ч дэлхий даяар тэрбум гаруй хүн шаардлагад нийцсэн орон байранд амьдарч чадахгүй байна. Дэлхийн өнцөг булан бүрт сая сая хүн амь нас, эрүүл мэндэд нь эрсдэлтэй хэт олноороо суурьшсан ядуусын хороолол, албан бус суурин газарт, эсхүл эрхээ эдлэх, нэр төртэй амьдрах боломжгүй хүнд нөхцөлд амьдарсаар байна. Түүнчлэн, жил бүр хэдэн сая хүн албадан нүүлгэлтэд өртөж, эсхүл албадан нүүлгэгдэх эрсдэл дунд аж төрж байна.

Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг 1948 онд батлагдсан НҮБ-ын Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон 1966 онд батлагдсан Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пактаар амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх эрхийн агуулгаар тус тус хамгаалжээ. Энэ үеэс хойш шаардлагад нийцсэн орон байртай байх эрх болон түүний зарим илрэх хэлбэр (тухайлбал, орон байр болон хувийн халдашгүй байдал)-ийг олон улсын хүний эрхийн бусад гэрээ, конвенцээр баталгаажуулсаар байна.

Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хангаж, хамгаалах нь бүх улс оронд хамааралтай билээ. Улс орнууд шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг баталгаажуулсан дор хаяж нэг олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орж, соёрхон баталсан нь холбогдох олон улсын тунхаг бичиг, төлөвлөгөө, хөтөлбөр, хурал чуулганы үр дүнгийн баримт бичигт заасны дагуу шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хамгаалах үүрэгтэй болгодог. Зарим улс Үндсэн хуулиараа дээрх эрхийг хуульчлан баталгаажуулж, амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх, шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хүндэтгэх, хамгаалах асуудлаар Засгийн газрын хүлээх үүргийг хуульчилсан байдаг. Түүнчлэн уг эрхийг хэрэгжүүлэх, ашиглахтай холбоотой үүссэн эрх зүйн маргаан, албадан нүүлгэн шилжүүлэлт, эзэмших эрх, орон байр болон түүнтэй холбоотой үндсэн үйлчилгээг авах хүрээнд үүссэн аливаа алагчлал, ялгаварлан гадуурхалттай холбоотой маргаан зэргийг шийдвэрлэсэн улс орнуудын дотоодын шүүхийн шийдвэрүүд цөөнгүй гарчээ.

Шаардлагад нийцсэн орон байраар хангагдах эрхийг хамгаалах чиглэлд олон улсын байгууллага, нэн ялангуяа хүний эрхийн олон улсын гэрээний байгууллагууд, бүс нутгийн хүний эрхийг хамгаалах механизм болон Хүний Эрхийн Хороо (Хүний Эрхийн Зөвлөл хэмээн өөрчлөгдсөн) онцгойлон анхаарч байгааг дурьдах хэрэгтэй. Энэ бүхний үр дүнд 2000 онд “Амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх эрхийн бүрэлдэхүүн болох Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч”-ийг бий болгосон бөгөөд энэ нь уг эрхийн агуулга, цар хүрээг тодорхойлоход ихээхэн тус дөхөм болсон билээ.

Энэхүү мэргэжлийн гарын авлага нь шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн агуулга, мөн чанарыг тайлбарлахын зэрэгцээ нийгмийн тодорхой бүлэг, хувь хүмүүст уг эрх ямар ач холбогдолтой болох, төрөөс уг эрхийг хэрхэн хамгаалах зэрэг асуудлыг хөндөнө. Түүнчлэн уг эрхийг хамгаалахад чиглэсэн үндэсний, бүс нутгийн болон олон улсын хариуцлага, хяналтын механизмыг авч үзнэ.

НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын Газар (ХЭДКГ) болон НҮБ-Хабитатаас хамтран боловсруулсан уг мэргэжлийн гарын авлага нь НҮБ-ын ХЭДКГ-ын хувьд Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн асуудлаар НҮБ-ын бусад байгууллагатай хамтран боловсруулсан хоёрдахь удаагийн хамтын бүтээл юм. Өмнө нь бид Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагатай хамтран Эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн асуудлаар, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагатай хамтран эрүүл хүнсээр хангагдах эрхийн асуудлаар мэргэжлийн гарын авлагыг боловсруулан хэвлэсэн билээ.

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН



# I. ШААРДЛАГАД НИЙЦСЭН ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХ ГЭЖ ЮУ ВЭ?

## A. Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн талаарх үндсэн ухагдахуун

НҮБ-ын Эдийн засаг, Нийгэм, Соёлын эрхийн Хороо (Хороо)-оос шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн агуулгыг хэт нарийвчлан тайлбарлах нь зохисгүй гэж үзжээ. Харин үүний оронд уг эрхийг аливаа хүн аюулгүй, амар амгалан, нэр төртэй амьдрах орчин хэмээн тодорхойлжээ. Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн мөн чанар, агуулгыг тодорхойлоход 1991 онд Хорооноос гаргасан Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн талаарх Ерөнхий Зөвлөмж №4 болон 1997 онд гаргасан Албадан нүүлгэн шилжүүлэлтийн талаарх Ерөнхий Зөвлөмж №7 чухал үүрэг гүйцэтгэдэг.<sup>1</sup>

- **Шаардлагад нийцсэн орон байртай байх эрх нь дараах эрх чөлөөг өөртөө агуулдаг.** Үүнд:
  - Албадан нүүлгэх болон орон байрыг нь хүч хэрэглэн нураах, эвдэх явдлаас хамгаалагдсан байх;
  - Орон байр, хувийн болон гэр бүлийн амьдралд нь хөндлөнгөөс дур мэдэн оролцох явдлаас ангид байх эрх;
  - Оршин суух болон амьдрах газраа сонгох, чөлөөтэй шилжин суурьших эрх;
- **Шаардлагад нийцсэн орон байртай байх эрх нь дараах эрхийг өөртөө агуулдаг.** Эдгээр эрхэд:
  - Эзэмшлийн аюулгүй байдал
  - Орон байр, газар болон эд хөрөнгийн нөхөн олговор
  - Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхээ тэгш, аливаа ялгаварлалгүйгээр эдлэх
  - Үндэсний болон орон нутгийн түвшинд орон байртай холбоотой шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох эрх

<sup>1</sup> Ерөнхий Зөвлөмжийг олон улсын гэрээний дагуу байгуулагдсан эрх бүхий байгууллагаас хийсэн хяналт, шинжилгээний үр дүнд үндэслэн боловсруулдаг. Энэхүү Ерөнхий Зөвлөмжүүд нь олон улсын гэрээний үүргээ гишүүн улс орнууд гүйцэтгэхэд нь мэргэжлийн удирдамж болдог.

- **Шаардлагад нийцсэн орон байрыг дөрвөн хана, тааз хэмээн хэт өрөөсгөл байдлаар ойлгож болохгүй.** “Шаардлагад нийцсэн орон байр” мөн эсэхийг авч үзэхийн тулд аливаа барилга, байгууламж нь хэд хэдэн нөхцөл, шаардлага хангасан байх хэрэгтэй. Эдгээр нь суурь хангамж, орон байрны хүрэлцээ зэрэг үндсэн шалгуур бөгөөд шаардлагад нийцсэн орон байр нь наанадаж дараах шалгуурыг хангасан байх шаардлагатай.
  - *Эзэмшлийн аюулгүй байдал:* албадан нүүлгэлт, хүчирхийлэл болон аливаа халдлагаас ангид байх талаарх оршин суугчдын эзэмшлийн аюулгүй байдлыг хуулиар хамгаалаагүй бол энэ нь шаардлагад нийцсэн орон байр гэх шалгуурт нийцэхгүй.
  - *Үйлчилгээ, материал, байгууламж, дэд бүтцийн хүртээмж:* тухайн орон байранд оршин суугч нь ундны цэвэр ус, ариун цэврийн байгууламж, цахилгаан, халаалт, гэрэлтүүлгээр хангагдаагүй, хоол хүнсээ хадгалах болон хог хаягдал зайлуулах боломжгүй бол шаардлагад нийцсэн орон байр гэж үзэхгүй.
  - *Худалдан авч болохуйц байх:* тухайн орон байр нь хэт өндөр үнэтэй бөгөөд энэ нь оршин суугчийг бусад эрх, эрх чөлөөгөө эдлэх боломжийг бууруулж байгаа бол шаардлагад нийцсэн хэмээн үзэхгүй.
  - *Оршин суухад тохиромжтой байх:* орчны аюулгүй байдал хангагдаагүй, зай талбай хомс, хүйтэн, халуун, бороо, салхи зэрэг хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хүчин зүйл болон орчны аюул, эрсдэлээс баталгаатай хамгаалахгүй бол тухайн орон байрыг шаардлагад нийцсэн гэж үзэхгүй.
  - *Хүртээмжтэй байх:* нийгмийн эмзэг бүлгийн хэрэгцээ шаардлагыг тусгайлан харгалзаж үзээгүй бол шаардлагад нийцсэн хэмээн үзэхгүй.
  - *Байрлал:* ажил, хөдөлмөр эрхлэх боломж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, сургууль, цэцэрлэг болон нийгмийн бусад үйлчилгээнээс алслагдсан, эсхүл орчны бохирдол ихтэй, аюултай газарт байгаа бол шаардлага хангаагүй хэмээн үзнэ.
  - *Соёлын онцлогт нийцсэн:* Соёлын онцлогоо илэрхийлэх хэрэгцээ, шаардлагыг харгалзан үзээгүй, уг асуудлыг хүндэтгээгүй бол шаардлагад нийцсэн гэж үзэхгүй.
- **Албадан нүүлгэлтээс хамгаалагдсан байх.** Албадан нүүлгэлтээс хамгаалагдсан байх нь шаардлагад нийцсэн орон

байртай байх эрхийн үндсэн элемент бөгөөд энэ нь эзэмшлийн аюулгүй байдалтай салшгүй холбоотой байдаг.

Албадан нүүлгэлт гэдэг нь “аливаа хувь хүн, эсхүл гэр бүл, нийгмийн бүлгийн хүсэл зоригийн эсрэг тэдний эзэмшиж буй орон байр, газраас нь зохих эрх зүйн болон бусад хамгаалалтыг ашиглах боломж олгохгүйгээр түр болон урт хугацаагаар нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа”-г хэлнэ.<sup>2</sup> НҮБ-ын Хүн амын нутагшил, суурьшлын Хөтөлбөр (НҮБ-Хабитат)-ийн судалгаагаар дэлхийн даяар жил бүр 2 сая орчим хүн албадан нүүлгэлтэд өртөж байдаг бол сая сая хүн албадан нүүлгэгдэх эрсдэлтэй нөхцөлд аж төрж байна.<sup>3</sup>

Албадан нүүлгэлт хийх янз бүрийн үндэслэл, хэрэгцээ шаардлага байдаг. Тухайлбал, дэд бүтцийг хөгжүүлэх, хотын өнгө үзэмжийг нэмэгдүүлэх, хотыг дахин төлөвлөх, олон улсын томоохон арга хэмжээ зохион байгуулах, газрын эрхийн маргаан, зэвсэгт мөргөлдөөн болон нийгмийг хамарсан ялгаварлан гадуурхалт зэргийг дурьдаж болно. Албадан нүүлгэлт нь хүчирхийллийг нөхцөлдүүлж, нийгмийн ядуу бүлгийн иргэдэд сөргөөр нөлөөлдөг бөгөөд цаашид хүний эрх, эрх чөлөө ноцтой зөрчигдөх суурь шалтгаан болдог. Ихэнх тохиолдолд албадан нүүлгэлт нь шийдвэрлэхийг зорьсон тулгамдсан асуудлыг улам бүр хүндрүүлэх нь ч бий.

Албадан нүүлгэх шалтгаан, үндэслэлээс үл хамааран албадан нүүлгэлт нь хүний эрхийн ноцтой, бүдүүлэг зөрчил бөгөөд энэ нь шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн шууд зөрчил болно. Өргөн цар хүрээг хамарсан нүүлгэн шилжүүлэлтийг зөвхөн онцгой тохиолдолд олон улсын холбогдох зарчим, хэм хэмжээнд нийцсэн тохиолдолд хэрэгжүүлнэ.

ОИХ.МН  
СУДАЛГААНЫ САН

<sup>2</sup> Ерөнхий Зөвлөмж №7-д дурдсанаар “Хүний эрхийн олон улсын гэрээ болон түүнд нийцсэн хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж байгаа албадан нүүлгэлтийн үйл ажиллагааг хориглохгүй”. (4 дүгээр догол)

<sup>3</sup> НҮБ-ын Хабитат, *Хүн амын нутагшлын талаарх дэлхийн тайлан 2007: Хот, суурин газрын аюулгүй байдал, хамгаалалтыг нэмэгдүүлэх нь* (Найроби, 2007)

## **Нүүлгэн шилжүүлэлтийн үед авч хэрэгжүүлэх хамгаалалтын арга хэмжээ**

Хэрэв түрээслэгч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй, эсхүл хөрөнгөд хохирол учруулсан тохиолдолд төрөөс холбогдох хууль тогтоомжийг үндэслэн, үндэслэл бүхий байдлаар, тухайн нөхцөл байдалд тохируулан, олон улсын хэм хэмжээнд нийцүүлэн нүүлгэн шилжүүлэлтийг хэрэгжүүлж болно. Энэ тохиолдолд нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн иргэдийн үл хөдлөх хөрөнгө болон хувийн өмчийн бусад хөрөнгөд тохирох нөхөн олговор олгох зэргээр тэдний эрхийг сэргээн эдлүүлэхэд чиглэсэн эрх зүйн үр нөлөөтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага тулгардаг. Нүүлгэн шилжүүлэлт нь хувь хүнийг орон гэргүй болгох, цаашид бусад эрх, эрх чөлөө нь зөрчигдөх үр дагаврыг бий болгох ёсгүй.

Олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд заасны дагуу Засгийн газар нь аливаа нүүлгэн шилжүүлэлтийг хийхээс өмнө асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар олон төрлийн хувилбарыг боловсруулж, хүч албадлага хэрэглэхээс аль болох зайлсхийх, эсхүл хамгийн бага түвшинд хэрэглэхийг эрмэлзэх ёстой. Хэрэв нүүлгэн шилжүүлэлтийг эцсийн арга болгон хэрэглэх тохиолдолд нөлөөлөлд өртсөн иргэдийг үр нөлөөтэй процедурын хамгаалалтаар хангах шаардлагатай. Үүнд:

- Бодитоор зөвлөлдөх боломжоор хангах;
- Шаардлага хангасан, үндэслэл бүхий мэдэгдэл өгөх;
- Төлөвлөсөн нүүлгэн шилжүүлэлтийн талаарх мэдээллийг хангалттай хугацааны өмнө өгөх;
- Нүүлгэн шилжүүлэлтийн үед төрийн албан хаагчид, эсхүл тэдний төлөөллүүд газар дээр нь ажиллах;
- Нүүлгэн шилжүүлэлтийг гүйцэтгэж буй хүн бүр биеийн байцаалттай байх;
- Нүүлгэн шилжүүлэлтийг цаг агаарын таагүй нөхцөлд болон шөнийн цагаар хийхгүй байх;
- Эрхээ хамгаалах боломжоор хангах;
- Шүүхээр гомдлоо шийдвэрлүүлэх зэрэг эрх зүйн тусламж, үйлчилгээ шаардлагатай иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх;

## **Б. Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн талаарх ташаа ойлголтууд**

- **Шаардлагад нийцсэн орон байртай байх эрх нь аливаа төр, засгийн газарт улсынхаа нийт хүн амд орон сууц барьж өгнө гэсэн утгыг илэрхийлэхгүй.** Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхтэй холбоотой олон нийтийн дунд хэвшин тогтсон ташаа ойлголтын нэг нь Засгийн газар улсынхаа иргэдийг орон байраар хангах үүрэгтэй, орон гэргүй хүмүүс Засгийн газраас орон байр олгохыг шаардаж болно хэмээн үзэх үзэл юм. Хэдийгээр ихэнх улсын Засгийн газраас орон сууцны чиглэлээр тодорхой үйл ажиллагаа хэрэгжүүлдэг ч, энэ нь Засгийн газар иргэддээ зориулан барилга, орон сууц барьж өгөх үүрэгтэй гэсэн утгыг илэрхийлэхгүй.

Зүй нь шаардлагад нийцсэн орон байртай байх эрх нь иргэдийг орон гэргүй болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, албадан нүүлгэлтийг хориглох, ялгаварлан гадуурхалтыг зогсоох, нийгмийн хамгийн эмзэг буюу эрх нь зөрчигдөх эрсдэлтэй бүлгийн эрх ашгийг чухалчлах, бүх иргэний эзэмшлийн аюулгүй байдлыг хангах, иргэдийн орон байр нь шаардлагад нийцсэн эсэхийг баталгаажуулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх утга санааг илэрхийлдэг. Эдгээр арга хэмжээ нь хууль тогтоох, захиргаа удирдлага, бодлого, төсөв санхүү гэх зэргээр төрийн засаглалын тогтолцооны бүх л түвшний бүрэн оролцоог шаарддаг. Төр бол орон сууцыг барьж байгуулдаг ханган нийлүүлэгч биш, харин орон сууц барьж байгуулах, засч сайжруулах зэрэг харилцаанд оролцогч холбогдох талуудын үйл ажиллагааг чиглүүлэгч гэсэн хандлагаар асуудлыг харах хэрэгтэй. НҮБ-аас 1988 оноос 2000 он хүртэл авч хэрэгжүүлэх “Орон байрны талаар баримтлах Дэлхийн Стратеги” баримт бичиг гаргасан бөгөөд үүний хүрээнд дээрх хандлагад үндэслэсэн бодлого, стратеги, хөтөлбөрүүдийг дэмжин ажилласаар ирсэн билээ.

Гэхдээ зарим тохиолдолд төр, Засгийн газраас байгалийн болон хүний хүчин зүйлээс үүдсэн гамшигт нэрвэгдсэн хүмүүс, түүнчлэн нийгмийн хамгийн эмзэг бүлгийн иргэдийг орон байраар хангах, орон байрны тэтгэмж үзүүлэх зэргээр шууд дэмжлэг үзүүлж болно. Өөрөөр хэлбэл, шаардлагад нийцсэн

орон байртай байх эрхийг хангах, хамгаалах арга хэмжээ гэдэг нь Засгийн газраас зарим нэг тодорхой үйл ажиллагаа, үйлдэл хийхгүй байх, татгалзах гэсэн утга юм.

- **Шаардлагад нийцсэн орон байртай байх эрх бол урт хугацаанд хэрэгжүүлэх энгийн нэг зорилт төдий зүйл биш.** Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хангаж, хамгаалах үүргээ төрөөс нэн даруй хэрэгжүүлэх ёсгүй хэмээн үзэх нь өрөөсгөл ойлголт юм. Харин ч эсрэгээрээ төр уг эрхийг хамгаалахад чиглэсэн шаардлагатай бүхий л арга хэмжээг өөрийн дотоод нөөц бололцоондоо нийцүүлэн, аль болох цаг алдалгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай. Нөөцийн хязгаарлагдмал байдлаас үл хамааран төрөөс зарим үүргээ нэн даруй хэрэгжүүлэх үүрэгтэй. Тухайлбал, шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн харилцаанд тэгш, үл ялгаварлах зарчим хэрэгжих баталгааг хангах, шаардлагатай хууль эрх зүй, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, албадан нүүлгэлтээс урьдчилан сэргийлэх, тодорхой хэмжээгээр иргэн бүрийн эзэмшлийн аюулгүй байдлыг баталгаажуулах зэрэг болно.
- **Шаардлагад нийцсэн орон байртай байх эрх нь хүмүүсийг нүүлгэн шилжүүлэхэд хүргэдэг хөгжлийн төслийг хориглон хязгаарладаггүй.** Албадан нүүлгэлтээс хамгаалагдсан байх нь нүүлгэн шилжүүлэхэд хүргэдэг аливаа хөгжил, шинэчлэлийн төлөө төслүүдийг хориглодог хэмээн зарим тохиолдолд үзэх нь бий. Хурдацтай тэлж буй хотын зарим хэсгийг дахин төлөвлөх, дэд бүтэц болон нийтийн зориулалтаар ашиглах газар олж авах зэрэг зайлшгүй хэрэгцээ төрд тулгарч байдаг. Дээрх хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагад нийцсэн орон байраар хангагдах эрх саад болдоггүй хэдий ч үйл ажиллагааг зохистой байдлаар хэрэгжүүлэх нөхцөл, журмын зарим хязгаарлалтыг бий болгодог. Аливаа төсөл, хөтөлбөрийг төлөвлөж хэрэгжүүлэх арга замыг зөв тодорхойлох нь ихээхэн чухал ач холбогдолтой. Гэвч төрийн байгууллагаас хөгжилд чиглэсэн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ уг үйл ажиллагаанд өртөж, эрх ашиг нь хөндөгдөж буй иргэдтэй зөвлөлдөхгүй байх, эсхүл нэр төдий зөвлөлдөх, тэдний хэрэгцээ, шаардлагыг хэт хязгаарлагдмал хүрээнд тодорхойлох, нүүлгэн шилжүүлэлт болон түүнээс үүдэх хохирлын хэмжээг багасгах арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд ач холбогдол өгөхгүй байх нь цөөнгүй тохиолддог.

- **Шаардлагад нийцсэн орон байртай байх эрх нь өмчлөх эрхээс ялгаатай.** Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг өмчлөх эрх болон эд хөрөнгийн эрхтэй адилтган үзэх нь түгээмэл байдаг. Түүнчлэн шаардлагад нийцсэн орон байртай байх эрх нь өмчлөх эрхийг үгүйсгэхэд хүргэдэг хэмээн шүүмжлэх нь ч бий. Өмчлөх эрхийг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт болон Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пактаар шууд хамгаалаагүй хэдий ч Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон Арьс үндсээр алагчлах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын Конвенц (5 дугаар зүйлийн (d) хэсгийн (v) заалт, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц (16 дугаар зүйлийн (h) хэсэг) зэрэг олон улсын гэрээ, конвенцоор хамгаалсан байдаг.<sup>4</sup>

Шаардлагад нийцсэн орон байртай байх эрх нь хүн бүрийн (эд хөрөнгийн өмчлөгч бус этгээдэд мөн хамаарна) аюулгүй, хамгаалагдсан орчинд амар тайван, нэр төртэй амьдрах утгыг илэрхийлдэг тул өмчлөх эрхээс хавьгүй өргөн хүрээтэй ойлголт юм. Тухайлбал, шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн тулгуур ойлголтын нэг болох эзэмшлийн аюулгүй байдал нь түрээсийн болон нийтийн байр, түр хоргодох эсхүл албан бус суурин, хувийн өмчийн орон байранд нэгэн адил хамааралтай. Тиймээс эзэмшлийн аюулгүй байдлыг зөвхөн албан ёсны бичиг баримттай эсэхээр хязгаарлаж ойлгож болохгүй.<sup>5</sup> Өргөн хүрээнд хамгаалагдсан шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг зөвхөн өмчийн эрхийн агуулгаар авч үзэх нь уг эрхийг зөрчихөд хүргэнэ. Тухайлбал, хувийн өмчийн орон сууцанд амьдран суугаа ядуусын хорооллын иргэдийг хүч албадлагаар нүүлгэх нь уг эрхийн зөрчил болно. Нөгөө талаар өмчийн эрхийн хамгаалалт нь тодорхой нийгмийн бүлгийн иргэд шаардлагад нийцсэн орон байртай байх эрхээ эдлэхэд нь чухал ач холбогдолтой. Тухайлбал, гэрлэгчид гэр бүлийн хөрөнгийн хувьд адил тэгш эрхтэй бөгөөд энэ нь эмэгтэйчүүдийн хувьд шаардлагад нийцсэн орон байртай байх

<sup>4</sup> Өмчлөх эрхийг Хүний эрхийн Америкийн Конвенц (21 дүгээр зүйл), Хүний болон ард түмний эрхийн талаарх Африкийн Харти (14 дүгээр зүйл) болон Европын Холбооны Үндсэн эрхийн Харти (17 дугаар зүйл) зэрэг баримт бичгээр хамгаалсан байдаг.

<sup>5</sup> НҮБ-Хабитат-ийн дэмжлэгтэй Дэлхийн Газрын Хэрэгслийн Сүлжээ нь хувь хүний газрын эрхийн асуудалд анхаарал хандуулахаас илүүтэйгээр газрын эрхийн тогтвортой байдлыг бий болгох замаар даян дэлхийн түвшинд хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилготой юм. [www.gltm.net](http://www.gltm.net). Сайтаас дэлгэрэнгүй мэдээллийг авна уу.

эрхийг тэгш, үл ялгаварлалгүй эдэлж хэрэгжүүлэх чухал хүчин зүйл болно.

- **Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг газрын эрхтэй адилтган үзэж болохгүй.** Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг газрын эрхтэй агуулгын хувьд адилтган үзэх хандлага ажиглагддаг. Газрын эрх нь шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хэрэгжүүлэх үндсэн элементийн нэг юм. Ялангуяа уг эрх нь орон нутгийн болон уугуул иргэдэд онцгой ач холбогдолтой. Харин шаардлагад үл нийцсэн орон байртай байх, албадан нүүлгэгдэх зэрэг нь иргэдийн газар болон бусад хөрөнгийн эх үүсвэр олж авах боломжийг үгүйсгэж, хязгаарласнаас үүдэлтэй байх магадлалтай. Иймээс зарим тохиолдолд шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хэрэгжүүлэхийн тулд газар эзэмших эрхийн баталгааг хангасан байх шаардлага тулгардаг. Гэхдээ хүний эрхийн олон улсын хуулиар одоогоор газартай холбоотой бие даасан хүний эрхийг баталгаажуулаагүй байна.<sup>6</sup>
- **Шаардлагад нийцсэн орон байртай байх эрх нь нийгмийн зохистой үйлчилгээг авах эрхийг өөртөө багтаадаг.** Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг тухайн барилга, байгууламж чанар, зохион байгуулалтын хувьд шаардлагад нийцсэн байх ёстой хэмээн хэт хязгаарлагдмал хүрээнд ойлгож болохгүй. Үүний зэрэгцээ хүн бүр эрүүл мэнд, аюулгүй байдал, ая тухтай байдлыг хангахад чиглэсэн тогтвортой, үл ялгаварлах зарчимд нийцсэн нийгмийн үндсэн үйлчилгээг хүртэх эрхтэй. Үүнд: ундны цэвэр ус, өрхийн зайлшгүй хэрэгцээ болох халаалт, гэрэлтүүлэг, бохир зайлуулахад хэрэглэх эрчим хүч, хоол хүнсээ хадгалах газар, хог хаягдал болон үерийн ус зайлуулах байгууламж, яаралтай тусламж үйлчилгээ авах зэргийг нэрлэж болно.

<sup>6</sup> “Амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх эрхийн бүрэлдэхүүн хэсэг болох шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч Милүн Котарийн тайлан”, (A/HRC/4/18, 26 болон 31 дэх догол). Тусгай илтгэгчийн зүгээс шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн үндсэн элемент болох газрын эрхийн ач холбогдлыг онцлон тэмдэглээд, “газрын эрхийг олон улсын хүний эрхийн хууль тогтоомжоор хүлээн зөвшөөрч баталгаажуулахыг Хүний Эрхийн Зөвлөлд хандан уриалжээ”.



## **В. Шаардлагад нийцсэн орон байртай байх эрх ба хүний бусад эрхийн харилцан хамаарал**

Хүний эрх нь бие даасан, салшгүй, өөр хоорондоо харилцан хамааралтай байдаг. Энэ утгаараа шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн зөрчил нь бусад олон төрлийн эрх зөрчигдөхөд хүргэнэ.

Харин уг эрхийг баталгаатай эдлэх нь хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалуулах, нийгмийн баталгаагаар хангагдах, сонгох, сурч боловсрох болон халдашгүй байх гэх зэрэг эрхийг эдэлж, хэрэгжүүлэх урьдач нөхцөлийг бүрдүүлнэ. Хүнийг амьдран суугаа газраас нь албадан нүүлгэж, хөдөлмөрлөх эрхээ хэрэгжүүлэх боломжгүй газарт амьдруулах нь орлого олох боломжийг нь хязгаарлах эрсдэлтэй. Түүнчлэн тогтсон хаягийн бүртгэл байхгүйгээс орон гэргүй хүмүүс сонгох эрх болон нийгмийн үйлчилгээ, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрхээ эдэлж чадахгүйд хүрнэ. Ялангуяа албан бус суурин зэрэг ядуусын хорооллын хүүхдүүд албан ёсны бүртгэл, бичиг баримтгүйн улмаас сургуульд хамрагдаж, сурч боловсрох боломжгүй болно. Шаардлагад үл нийцсэн орон байр нь иргэдийн эрүүл мэндэд хортой үр дагавар бий болгодог. Ялангуяа ундны цэвэр ус болон ариун цэврийн байгууламжаар хангагдаагүй байх зэрэг нь хүмүүсийг хүндээр өвчлөхөд хүргэдэг.

Албадан нүүлгэлт нь сурч боловсрох, аюулгүй байх зэрэг хэд хэдэн эрх зөрчигдөхөд хүргэдэг. Хүүхдүүд сургууль завсардах, сургуульд хамрагдаж чадахгүй байх нь албадан нүүлгэлтээс үүдэх ноцтой үр дагаврын нэг юм. Учир нь албадан нүүлгэлтэд өртсөний дараах хүндрэл бэрхшээлүүд нь хүүхдийн сурч боловсрох чадамжид сөргөөр нөлөөлдөг. Албадан нүүлгэлтийн үеэр хүмүүс хүчирхийлэл, зодож дарамтлах үйлдлийн хохирогч болохын зэрэгцээ зарим тохиолдолд амь насаа алдах нь ч бий. Эмэгтэйчүүд, хүүхдүүд нь албадан нүүлгэлтийн өмнө, тухайн үед, түүнээс хойш бэлгийн хүчирхийлэл гэх зэрэг аливаа төрлийн хүчирхийлэлд өртөх өндөр эрсдэлтэй нийгмийн бүлэгт хамаардаг.

Үүний зэрэгцээ бусад эрхийн хэрэгжилт нь шаардлагад нийцсэн орон байртай байх эрхэд ихээхэн нөлөөлнө. Сурч боловсрох, хөдөлмөрлөх, нийгмийн баталгаагаар хангагдах эрх нь зөрчигдсөн хүмүүсийн хувьд орон байртай байх эрхээ хэрэгжүүлэхэд ихээхэн хүндрэл тулгардаг. Орон байрны нөхцөлөө сайжруулах, албадан нүүлгэлтээс хамгаалагдах

эсэх асуудал эрх, ашиг нь хөндөгдөж, зөрчигдсөн иргэд хэр их гомдол гаргахаас ихээхэн шалтгаалдаг. Үзэл бодлоо илэрхийлэх, хуран цуглах, эвлэлдэн нэгдэх зэрэг эрх, эрх чөлөөнд хүндэтгэлгүй ханддаг газарт иргэд болон нийгмийн тодорхой бүлгийнхний амьдралаа дээшлүүлэх, сайжруулах талаар дуугарах, хэлж ярих нь мэдэгдэхүйц буурдаг байна. Иргэдийн шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хамгаалах чиглэлээр ажиллаж буй хүний эрхийн хамгаалагчид хүчирхийлэл, дур зоргоор баривчлах, шүүхээс гадуур болон урт хугацаагаар баривчлах зэрэг хууль бус үйлдэлд өртсөөр байна.

## **Г. Үл ялгаварлах зарчмыг хэрхэн хэрэглэх вэ?**

Ялгаварлан гадуурхалт гэдэг нь аливаа хүнийг арьс үндэс, шашин шүтлэг, нас, хүйс гэх зэрэг онцлогт нь үндэслэн хүний эрх, үндсэн эрх чөлөөг нь хүлээн зөвшөөрөх, эдэлж, хэрэгжүүлэх боломжийг үгүйсгэх, хязгаарлах зорилго, үр дагаврыг бий болгодог аливаа үйлдлийг хэлнэ. Ялгаварлан гадуурхалт нь нийгмийн тодорхой бүлгийг шахан хавчих ойлголттой шууд холбоотой бөгөөд ихэнх тохиолдолд нийгмийн бүтцийн тэгш бус байдлын үндэс суурь болж байдаг.

Орон байртай байх ойлголтын тухайд ялгаварлан гадуурхах байдал нь дараах хэлбэрээр илэрч болно. Үүнд: ялгаварлан гадуурхсан хууль тогтоомж, бодлого, арга хэмжээ хэрэгжүүлэх, нийгмийн зарим бүлгийг орхигдуулсан бодлого боловсруулах, орон байрны хөнгөлөлт, халамж, тэтгэмжид үл хамруулах, оршин суугчийн эзэмшлийн аюулгүй байдлыг үгүйсгэх, зээлжих эрхийн баталгаа буюу зээлийн түүх үүсгэх боломж хангалтгүй байх, иргэний байр сууринаас нутгийн эрх бүхий байгууллагын шийдвэр гаргах үйл явцад оролцох боломж хязгаарлагдмал байх, хувийн хэвшлийн зүгээс гаргах ялгаварлан гадуурхах аливаа үйлдлээс хамгаалагдах баталгаа хангалтгүй байх зэрэг болно.

Үл ялгаварлагдах болон эрх тэгш байх нь хүний эрхийн үндсэн зарчим бөгөөд шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пактын 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт оролцогч улсууд хүнийг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, төрсөн болон бусад нөхцөл байдлаар алагчлахгүй байх талаар тусгасан. Эдийн засаг, Нийгэм, Соёлын эрхийн Хорооны

тодорхойлсноор “бусад нөхцөл” гэдэгт хөгжлийн бэрхшээл, эрүүл мэндийн байдал (ХДХВ/ДОХ) эсхүл бэлгийн чиг баримжаа зэргийг хамруулж болно. Ядуурал, эдийн засгийн чадамжийн дорой байдлаас үүдэн орон байртай байх эрхийн харилцаанд ялгаварлан гадуурхалт үүсэж байгааг Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч онцлон тэмдэглэжээ.

Хэрэв аливаа хүн арьс үндэс, хүйс, үндэсний гарал, хөгжлийн бэрхшээлтэй байдал гэх зэрэг хэд хэдэн шинжээр ялгаварлан гадуурхалтад өртсөн тохиолдолд үүсэх сөрөг үр дагавар нь улам бүр нэмэгддэг. Хорооны зүгээс энэ төрлийн ялгаварлан гадуурхалтын асуудлыг үр нөлөөтэй шийдвэрлэхийн ач холбогдлыг эдийн засаг, нийгэм, соёлын бүх эрхийг эрэгтэй, эмэгтэй хүн бүрт тэгш эдлүүлэх нөхцөлийг хангах талаарх 2005 онд гаргасан 16 тоот Ерөнхий Зөвлөмждөө онцлон тэмдэглэсэн.

Улс орнууд нь аливаа нөхцөлөөр ялгаварлан гадуурхахыг хориглох, устгах үүрэгтэй бөгөөд шаардлагад нийцсэн орон байраар хангагдах, албадан нүүлгэлтээс хамгаалагдах хууль зүйн болон бусад баталгааг эрх тэгш байдлаар бүрдүүлэх үүрэгтэй.

#### **Д. Хүний эрхийн олон улсын хэм хэмжээгээр шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хамгаалсан нь**

Шаардлагад нийцсэн орон байртай байх эрх нь амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх эрхийн бүрэлдэхүүн хэсэг болохын хувьд хүний эрхийн олон улсын хэм хэмжээгээр хамгаалагдсан байдаг. Юуны өмнө уг эрхийг Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгээр хамгаалсан. Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хамгаалах чухал баримт бичиг болох Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пактад *хүн бүрийн болон түүний өрх гэрийн хүрэлцээтэй хоол хүнс, хувцас, орон сууцыг оролцуулан, амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх, амьдралынхаа нөхцөлөө байнга сайжруулах эрхийг хүлээн зөвшөөрсөн* (11 дүгээр зүйл).

Дээр дурдсанчлан, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн Хорооноос шаардлагад нийцсэн орон байртай байх эрх болон орон байртай холбоотой асуудлаар Ерөнхий Зөвлөмж № 4, 7, 16-г тус тус гаргажээ. Эдгээр нь Пактын холбогдох заалтуудыг хэрэгжүүлэх ерөнхий удирдамж юм.

Олон улсын холбогдох бусад гэрээ, конвенцоор шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг зохицуулалтын зорилгодоо нийцүүлэн янз бүрийн арга замаар хамгаалсан байдаг. Эдгээрийн зарим нь нийтлэг, ерөнхий зохицуулалтыг агуулсан байхад нөгөө хэсэг нь нийгмийн тодорхой бүлэг, тухайлбал эмэгтэйчүүд, хүүхдүүд, уугуул иргэд, цагаач ажилчид болон тэдгээрийн гэр бүл, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг тусгайлан хамгаалсан байдаг.

**Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хамгаалсан хүний эрхийн олон улсын бусад баримт бичиг**

- Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай НҮБ-ын Конвенц, 1951 он, (21 дүгээр зүйл)
- Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Нийгмийн бодлогын Үндсэн зорилго, хэм хэмжээний тухай баримт бичиг, 1962 оны 117 дугаар Конвенц (5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг)
- Арьс үндсээр алагчлах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын Конвенц, 1965 он, (5 дугаар зүйлийн (e) хэсгийн iii дахь заалт)
- Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт (17 дугаар зүйл)
- Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц (14 дүгээр зүйлийн 2 болон 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг)
- Хүүхдийн Эрхийн тухай Конвенц (16 дугаар зүйлийн 1 дэх хэсэг болон 27 дугаар зүйлийн 3 дахь хэсэг)
- Тусгаар тогтносон улс орнууд дахь Уугуул болон Омгийн хүмүүсийн талаарх Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын 1989 оны 169 дүгээр Конвенц (14, 16, 17 дугаар зүйлүүд)
- Цагаач ажилчид болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын Конвенц, 1990 он, (43 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (d) заалт)
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенц, 2006 он, (9 болон 28 дугаар зүйл)

Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг бүс нутгийн түвшний гэрээ, конвенцоор мөн хамгаалсан байдаг. Тухайлбал, Цагаач ажилчдын эрх зүйн байдлын талаарх Европын Конвенц (1977), Хүүхдийн эрх болон нийгмийн хамгааллын талаарх Африкийн Харти (1990), Европын Нийгмийн Харти (1996, дахин шинэчлэгдсэн). Харин Хүний эрх болон үндсэн эрх чөлөөг хамгаалах Европын Конвенц (1950), Европын Нийгмийн Харти (1961), Хүний эрхийн Америкийн Конвенц (1969), Хүний эрх болон ард түмний эрхийн Африкийн Конвенц (1981)-д шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг

тусгайлан хамгаалаагүй хэдий ч халдашгүй байдал, өмчлөх, эзэмших эрхээ чөлөөтэй хэрэгжүүлэх, гэр бүлээ хамгаалах эрх зэрэг хүний бусад эрхээ хэрэгжүүлэх эрх зүйн үндсэн суурь хамгаалалтын хүрээнд агуулгаар нь тусгасан байдаг.

**Хүний болон ард түмний эрхийн талаарх Африкийн Хартид Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хамгаалсан нь**

Нийгэм, Эдийн засгийн эрхийн үйл ажиллагааны Төв болон Эдийн засаг, Нийгмийн эрхийн Төвийн гомдолтой Нигери улсад холбогдох маргаан (дугаар 155/96)-ыг Хүний эрхийн болон ард түмний эрхийн Африкийн комиссоос шийдвэрлэх явцад шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг Хартийн заалтаар шууд хамгаалаагүй болохыг олж тогтоожээ.

*Хэдийгээр орон байртай байх эрхийг Африкийн Хартиар шууд хамгаалаагүй хэдий ч сэтгэцийн болон бие махбодын эрүүл мэндээ хамгаалуулах эрх,..., өмчлөх эрх, гэр бүлээ хамгаалах эрхийн хэрэгжилтийг хангах зорилгоор орон байрыг эвдэн сүйтгэх, нураах зэрэг балмад үйлдлийг хориглодог. Яагаад гэвэл энэ нь хүний эд хөрөнгө, эрүүл мэнд, гэр бүлийн амьдралд хортой, сөргөөр нөлөөлдөг хэмээн үздэг. Иймээс уг Хартийн 14, 16 болон 18 дугаар зүйлүүдийн агуулгыг өргөтгөн тайлбарлах замаар орон байртай байх эрхийг хамгаалжээ.*

Олон улсын хэд хэдэн удирдамж, зарчимд шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн талаар тусгасан байна. Эдгээр зохицуулт нь хууль зүйн хувьд заавал биелэгдэх шинжгүй хэдий ч шаардлагад нийцсэн орон байртай байх эрх, нэн ялангуяа ажилчид, дүрвэгсэд, дотоодын шилжин суурьшигчид, ахмад настнууд, уугуул иргэд гэх зэрэг нийгмийн тодорхой бүлгийн эрхийг бодитоор хамгаалах, хэрэгжүүлэхэд чиглэсэн удирдамж болдог онцлогтой.<sup>7</sup> Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгчийн бүрэн эрхийн хүрээнд боловсруулсан Хөгжилд суурилсан нүүлгэлт болон шилжилт хөдөлгөөний талаар баримтлах үндсэн зарчим, удирдамжийн ач холбогдлыг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Энэхүү зарчим, удирдамж нь хөгжилд суурилсан нүүлгэн шилжүүлэлтийн бүхий л процесс (бэлтгэл

<sup>7</sup> Ахмад настны талаар баримтлах НҮБ-ын зарчмууд, Дүрвэгсэд хийгээд дотоодын дүрвэгсдийн орон байр, эд хөрөнгийн эрхийг сэргээн эдлүүлэх талаар баримтлах НҮБ-ын зарчмууд, Ажилчдын орон байрны эрхийн асуудлын талаарх Олон улсын Хөдөлмөрийн Байгууллагын 115 дугаар зөвлөмж, Уугуул иргэдийн эрхийн талаарх НҮБ-ын тунхаглал.

үе шат, гүйцэтгэлийн болон гүйцэтгэлийн дараах үе шат)-т баримтлах төрийн онцгой үүрэг, хариуцлага хийгээд албан нүүлгэлтээс хүний эрхийг хамгаалах төрийн үүргийг тодорхойлсон байдаг.

**Хөгжилд суурилсан нүүлгэлт болон шилжилт хөдөлгөөний талаар баримтлах үндсэн зарчим, удирдамж**

22. Улс орнууд нь хүний эрхийг хамгаалах олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэгт нь үл нийцэх нүүлгэн шилжүүлэлтийг хориглосон хууль, бодлогын баримт бичгийг баталж, зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй...

32. ... хөгжилд суурилсан нүүлгэн шилжүүлэлтэд чиглэсэн аливаа төсөл, санаачилгыг хэрэгжүүлэхийн өмнө иж бүрэн, цогц үр нөлөөний үнэлгээ хийх шаардлагатай, ... "Нүүлгэн шилжүүлэлтийн үр дагавар"-ыг үнэлэхдээ учирч болох эрсдэл, хохирлыг аль болох хамгийн бага түвшинд байлгах олон хувилбар бүхий арга, стратегийг боловсруулсан байвал зохино.

37. Хот болон орон нутгийг төлөвлөх, хөгжүүлэх үйл ажиллагаанд уг үйл ажиллагааны улмаас эрх ашиг нь хөндөгдөж, зөрчигдөх боломжтой иргэдийн оролцоог хангах ...

38. Нүүлгэн шилжүүлэлтээс зайлсхийх боломжит бүх хувилбарыг төр судалж гаргана. ...

52. Холбогдох төрийн байгууллагууд нь нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн иргэдийн аюулгүй байдал, хамгаалалтыг хангахад чиглэсэн дараах үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх үүрэгтэй. (а) чухал шаардлагатай хоол хүнс, ундны цэвэр ус болон ариун цэврийн байгууламж; (б) үндсэн хамгаалалт буюу орон байр; (в) тохиромжит хувцас; (г) эрүүл мэндийн шаардлагатай тусламж, үйлчилгээ; (д) амь зуух орлогын эх үүсвэр; (е) малтай иргэдийг малын тэжээл болон бэлчээр зэрэг нийтийн хадлан тэжээлийн нөөцийг ашиглах боломжтой байлгах; (ё) хүүхдийн боловсрол болон хүүхдээ асран өсгөхөд шаардагдах бусад байгууламж. ...

55. Иргэдийг нүүлгэн шилжүүлэхээр төлөвлөсөн газар нь Хүний эрхийн олон улсын хэм хэмжээнд заасан шаардлагад нийцсэн орон байраар хангагдах эрхийн шалгуур үзүүлэлтүүдийг хангах ёстой.

Хүн амын суурьшлын талаарх Ванкуверын Тунхаглал (1976), Хөтөлбөр 21 (1992), Хүн амын суурьшлын талаарх Истанбулын Тунхаглал (1996), Хабитат Хөтөлбөр (1996), Мянган Тунхаглал болон Мянган

хөгжлийн зорилтууд (2000) зэрэг хурал, тунхаглал, үйл ажиллагааны төлөвлөгөөнүүд нь шаардлагад нийцсэн орон байртай байх эрх болон уг эрхийг хангаж, хамгаалах улс орнуудын үүргийг олон талаас нь авч үзэхэд дэмжлэг болсоор байна.

### **Хабитат Хөтөлбөр**

Хабитат II чуулганаас гаргасан Истанбулын Тунхаг бичиг буюу Хабитатын Хөтөлбөр нь хүн амын нутагшил, суурьшлын хөгжлийг хүний эрх, тэр дундаа орон байртай байх эрхийг хэрэгжүүлэх үйл явцтай нягт холбох үндсэн тогтолцоотой. *Хабитат Хөтөлбөрт тусгаснаар засгийн газрууд нь шаардлагад нийцсэн орон байртай байх хүний эрхийг хангаж хамгаалах, хөхиүлэн дэмжих, бүрэн, үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй.* (61 дэх догол)

Олон улсын Хүмүүнлэгийн эрх зүй нь олон улсын болон бусад зэвсэгт мөргөлдөөний үед шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг тусгайлан хамгаалахад чухал ач холбогдолтой.<sup>8</sup> Олон улсын Эрүүгийн Шүүхийн Ромын Дүрэмд зааснаар цэрэг дайны зайлшгүй шаардлага байхгүй байхад эд хөрөнгийг хууль бусаар, дураараа, зэрлэг балмадаар их хэмжээгээр устгах, нураах үйлдлийг дайны гэмт хэрэг хэмээн үзнэ (8 дугаар зүйл).

Эцэст нь тэмдэглэхэд Бельги, Сейшелийн арлын Бүгд найрамдах улс, Өмнөд Африк, Уругвай зэрэг улсын Үндсэн хуулиар шаардлагад нийцсэн орон байртай байх хүний эрхийг хуульчлан баталгаажуулжээ.<sup>9</sup> Зарим улсын Үндсэн хуулиар шаардлагад нийцсэн орон байртай байх эрх болон амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх эрхийг хангаж хамгаалах талаар төрийн үүргийг нийтлэг байдлаар зохицуулжээ.<sup>10</sup>

<sup>8</sup> Дайны үед энгийн иргэдийг хамгаалах талаарх Женевийн Дөрөвдүгээр Конвенц , (53 дугаар зүйл); Протокол I (69 дүгээр зүйл); Протокол II (17 дугаар зүйл).

<sup>9</sup> Эквадор, Гайана, Гаити, Гондурас, Иран (Исламын Бүгд Найрамдах улс), Мальдив, Мали, Мексик, Никарагуа, Панама, Парагвай, Перу, Португал, ОХУ, Сан-Томе ба Принсипи, Испани зэрэг улсын Үндсэн хуулийг харна уу.

<sup>10</sup> Аргентин, Бангладеш, Бразил, Буркина Фасо, Колумб, Коста Рика, Доминиканы Бүгд Найрамдах Улс, Эль Сальвадор, Финланд, Гватемалла, Непал, Нидерланд, Нигери, Пакистан, Филиппин, Польш, БНСУ, Шри Ланка, Швед, Швейцарь, Турк, Венесуэл (Боливийн Бүгд Найрамдах улс) болон Вьетнам зэрэг улсын Үндсэн хуулийг харна уу.

## **Зарим улс орны Үндсэн хуульд шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг баталгаажуулсан нь**

*Мексик улсын Үндсэн хууль, 1917 он (1983 онд нэмэлт, өөрчлөлт орсон)*  
4 дүгээр зүйл

[...] Гэр бүл бүр зохистой, шаардлагад нийцсэн орон байртай байх эрхтэй. Дээрх зорилгоо биелүүлэхэд нь шаардлагатай арга хэрэгсэл, дэмжлэгийг хуулиар тогтооно.

*Португал улсын Үндсэн хууль, 1976 он (дөрөв дэх удаагийн шинэчлэн найруулсан Үндсэн хууль № 1/97 1997 оны 9 дүгээр сарын 20)*

65 дугаар зүйл. Орон сууц болон хотжилтын төлөвлөлт

(1) Хүн бүр өөрийн болон гэр бүлийн хэрэгцээнд зориулан эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, тохь тухтай, хувийн болон гэр бүлийн аюулгүй байдлаа хангахуйц зохистой хэмжээ бүхий орон байртай байх эрхтэй.

*Оросын Холбооны Улсын Үндсэн хууль, 1993 он*

40 дүгээр зүйл

(1) Хүн бүр орон байртай байх эрхтэй. Хэнийг ч орон байрнаас нь хүчээр хагацааж болохгүй.

*Өмнөд Африкийн Үндсэн хууль, 1996 он*

26 дугаар зүйл. Орон байр

(1) Хүн бүр шаардлагад нийцсэн орон байртай байх эрхтэй.

(2) Төрөөс шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг баталгаатай хэрэгжүүлэхэд улсынхаа боломжит нөөц, эх үүсвэрийн хүрээнд хууль эрх зүйн болон бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй.

(3) Холбогдох бүх нөхцөл байдлыг бүрэн хянан үзэж гаргасан шүүхийн шийдвэргүйгээр хэнийг ч орон байрнаас нь хөөх эсхүл орон байрыг нь нураан, эвдэн сүйтгэж болохгүй. Хууль бусаар дур мэдэн нүүлгэн шилжүүлэхийг хориглоно.

28 дугаар зүйл. Хүүхэд

(1) Бүх хүүхэд орон байртай байх эрхтэй....

НҮБ-ын Орон байртай байх эрхийн Хөтөлбөрийг дэлгэрүүлэн үзнэ үү. "Тайлан №.1: Хүний эрхийн хууль тогтоомж: Олон улсын болон үндэсний эрх зүйн арга хэрэгслийн талаарх тойм" (2002).



## **II. ШААРДЛАГАД НИЙЦСЭН ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХИЙГ НИЙГМИЙН ТОДОРХОЙ БҮЛГИЙН ЭРХ АШИГТ НИЙЦҮҮЛЭН ХЭРХЭН ХЭРЭГЛЭХ ВЭ?**

Зарим хүмүүс, нийгмийн тодорхой бүлэг нь нийгэмд эзлэх байр суурь, ялгаварлан гадуурхалт болон бусад олон нөхцөл байдлын улмаас шаардлагад нийцсэн орон байртай байх эрхээ эдлэх явцдаа зарим хүндрэл бэрхшээлтэй тулгарсаар байна. Орон байртай байх эрхийг үр нөлөөтэй хамгаалахын тулд эрх ашиг нь хөндөгдөх эрсдэлтэй нөхцөлд амьдарч байгаа нийгмийн тодорхой бүлэг, хувь хүмүүсийн нөхцөл байдлыг онцгойлон авч үзэх шаардлагатай. Улс орнууд нь нийгмийн бүлэг болон хүмүүсийг зорилго, үр дүнгээр нь ялгаварлан гадуурхахгүй байх баталгааг хангахын тулд үр нөлөө бүхий эерэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй. Тухайлбал, төрийн зүгээс нийгмийн олонхид зориулсан орон байрны асуудлыг шийдвэрлэхэд холбогдох хууль, бодлогын баримт бичиг гаргахаас илүүтэйгээр орон байрны хэрэгцээ хамгийн их тулгамдсан нийгмийн зорилгод бүлгийн тусгай хэрэгцээг харгалзаж шийдвэрлэхээр чиглүүлэх хэрэгтэй.

Дор дурдсан нийгмийн тодорхой бүлгийн талаарх мэдээлэл нь шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг практикт хэрэгжүүлэхэд чиглэсэн хэм хэмжээг ойлгоход туслах болно.

### **A. Эмэгтэйчүүд**

Холбогдох тоо, мэдээг нарийвчлан тооцоолж гаргахад хүндрэлтэй хэдий ч шаардлагад үл нийцсэн орон байртай нийгмийн бүлгүүдийн үлэмж хувийг эмэгтэйчүүд бүрдүүлж байна. Эмэгтэйчүүд нь хүйс болон эд хөрөнгийн байдал (ядуурал), нас, нийгмийн аль давхаргад хамаарч байгаа эсэх, бэлгийн чиг баримжаа, үндэс угсаа зэрэг олон хүчин зүйлээс хамааран орон байртай байх эрхийн харилцаанд ялгаварлан гадуурхалтад өртсөөр байна. Дэлхийн өнцөг булан бүрт, ялангуяа хөдөө орон нутагт оршин суугаа эмэгтэйчүүдийн хувьд шаардлагад нийцсэн орон байртай байх эрхээ хэрэгжүүлэх гол хүчин зүйл нь газар болон хөрөнгийн эрх олж авах, хэрэгжүүлэх ойлголттой шууд холбоотой байдаг.

## **Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц**

### **14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг**

Оролцогч улсууд нь эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхийн үндсэн дээр хөдөө нутагт эмэгтэйчүүдийг алагчлах үзлийг устгах үүднээс эмэгтэйчүүд хөдөө нутгийн хөгжилд оролцож, түүнээс ашиг хүртэх талаар зохистой бүх арга хэмжээг авч, тэднийг дараах эрхээр хангана:

[...]

(ж) амьдралын зохих нөхцөлөөр, ялангуяа орон сууц, ариун цэвэр, цахилгаан болон усан хангамж, тээвэр, харилцаа холбоогоор хангагдах.

**15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг** Оролцогч улсууд эмэгтэйчүүдэд иргэний харилцаанд эрэгтэйчүүдтэй тэгш эрх зүйн чадамж, түүнийг хэрэгжүүлэх тэгш боломж олгоно. Тухайлбал, гэрээ байгуулах болон эд хөрөнгө захиран зарцуулах тэгш эрхийг олгож, шүүх, тусгай шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх бүх шатанд тэдэнд тэгш хандана.

Орон байрны харилцаанд эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах үйлдэл нь олон хүчин зүйлээс үүдэлтэй байж болно. Тухайлбал, ялгаварлан гадуурхсан хуулийн зохицуулалт; жендэрийн төвийг сахисан хууль болон эмэгтэйчүүдийн онцгой нөхцөл байдлыг чухалчлан авч үзээгүй бодлогын алдаа (хүйс болон жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөх өндөр эрсдэлтэй байх); эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан гадуурхалтыг өөгшүүлсэн уламжлалт зан заншил, практикт хэвшин тогтсон ойлголт, хандлага; шүүх болон захиргааны байгууллагад тогтсон хэт нэг талыг барих үзэл; зөрчигдсэн эрхээ сэргээлгэх, мэдээлэл олж авах болон шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог хангахгүй байх, эрхийн талаарх мэдлэг, мэдээлэл хангалтгүй байх зэргийг нэрлэж болно. Дээрх ялгаварлан гадуурхалт нь нийгмийн бүтэц болон түүхэн хүчин зүйлээс хамаардаг.

**ОИХ.МН**  
**СУДАЛГААНЫ САН**

## Эмэгтэйчүүд болон өв залгамжлал

Охид, эмэгтэйчүүдийг өв залгамжлалын харилцаанд ялгаварлан гадуурхах нь шаардлагад нийцсэн орон байртай байх эрхээ хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж байгааг дэлхийн олон орны нөхцөл байдал харуулж байна. Дээрх хэлбэрийн ялгаварлан гадуурхалт нь өв залгамжлалын харилцаанд эмэгтэйчүүдийн эрхийг эрэгтэйчүүдтэй эрх тэгш авч үздэггүй алдаатай хууль тогтоомж, зан заншлын хэм хэмжээ болон бусад үйл ажиллагаанаас үүдэлтэй юм. Үүний үр дүнд эмэгтэйчүүд эрэгтэй өв залгамжлагчидтай харьцуулахад бага хэмжээний өв хөрөнгө хүлээн авах, эсхүл нас барсан нөхөр, эсхүл эцгийнхээ хөрөнгийг өвлөх эрхээ алдаж байна.

Эмэгтэйчүүдийн өв хөрөнгийг төрөл, садны хүмүүс нь хүчээр булаан авах, бие махбодын болон сэтгэл санааны хүч хэрэглэх, удаан хугацааны гэмтэл учруулах зэргээр өв залгамжлалын харилцаанд эмэгтэйчүүдийн эрхийг зөрчих байдал түгээмэл байна. Төрөл, садан нь бэлэвсэн эмэгтэйчүүдтэй ихэвчлэн зүй бусаар харьцдаг бөгөөд гэр бүлийн дотоод асуудал гэсэн үндэслэлээр уг үйлдэлдээ ямар нэгэн хариуцлага хүлээдэггүй байна.

Хэрэв тухайн эмэгтэй өв хөрөнгийнхөө төлөө тэмцэж, хариу үйлдэл хийсэн тохиолдолд нөхрийн ар гэрийнхэн болон тухайн газар нутгийн хүмүүсийн хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй. Ерөнхийдөө, эмэгтэйчүүдийн өвлөх эрхээ хамгаалахаар гаргасан гомдол, нэхэмжлэл нь зөвхөн гэр бүлийнхний төдийгүй нийгмийн зүгээс ирэх хавчлага, гадуурхалтаар эцэс болох нь түгээмэл байдаг.

Дэлгэрэнгүйг “Эмэгтэйчүүд болон шаардлагад нийцсэн орон байр: Амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх эрхийн бүрэлдэхүүн хэсэг болох шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч Милүн Котарийн судалгаа” (E/CN.4/2005/43, 59–61 догол мөр)-аас харна уу.

Эмэгтэйчүүд эзэмшлийн аюулгүй байдлын хувьд ноцтой ялгаварлан гадуурхалтад өртдөг. Хөрөнгийн төрлөөс үл хамааран аливаа газар, барилга, өмч хөрөнгийг эрэгтэйчүүдийн өмч хэмээн үзэх, тэдний нэр дээр бүртгэдэг зэргээс үүдэн эмэгтэйчүүд эзэмшлийн аюулгүй байдлын хувьд эрэгтэйчүүдээс хэт хамааралтай болдог. Түүнчлэн, хамтын эзэмшлийн хэлбэрт эмэгтэйчүүд орж болох ч тухайн хөрөнгөтэй холбоотой аливаа шийдвэр гаргах үйл ажиллагаанд эрэгтэйчүүдийн оролцоо давамгайлах нь нийтлэг байна.

Орон байр, газар болон бусад хөрөнгөө эрхлэн удирдаж чадахгүй байх нь эмэгтэйчүүдийн хувийн болон эдийн засгийн бие даасан байдлыг алдагдуулж, улмаар нийгэм, бүлэг, гэр бүлийн гишүүдийн аливаа зүй бус нөлөөнд өртөх эрсдэлийг улам нэмэгдүүлдэг. Хэрэв эмэгтэйчүүд орон байр, газар, бусад хөрөнгөө хэн нэг гуравдагч этгээд болох нөхөр, ах, эцэг болон бусад эрэгтэй хамаатнаас хэт хамааралтай байдлаар олж авсан бөгөөд тэдэнтэй харилцах харилцаа дуусгавар болсон тохиолдолд орон гэргүй болох, эсхүл ядуурал, гачигдалтай нүүр тулах болно.

Албадан нүүлгэлт нь эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд сөргөөр нөлөөлөх хэдий ч эмэгтэйчүүдэд илүү хүнд тусдаг байна. Нүүлгэн шилжүүлэлтийн өмнө, үеэр эсхүл дараах аль ч үе шатанд эмэгтэйчүүд хүнд хэлбэрийн сэтгэл санааны дарамтад орох, хүчирхийлэлд өртөх эрсдэлтэйд тооцогддог. Учир нь эмэгтэйчүүд орон гэрийнхээ дотоод асуудал болон гэр бүлдээ халамж анхаарал тавих зэрэг чухал үүрэг гүйцэтгэдэг.<sup>11</sup> Нүүлгэн шилжүүлэлтийн явцад эмэгтэйчүүдийг хэл амаар доромжлох, зодох, бие махбодын хүч хэрэглэх, хүчиндэх зэргээр эрхийг нь зөрчих явдал цөөнгүй тохиолддог. Харин нүүлгэн шилжүүлэлтийн дараа эмэгтэйчүүд шаардлагад үл нийцэх орон байранд тэр дундаа албан бус сууринд хүчээр шилжин суурьшсан тохиолдолд аливаа эрсдэлд илүү өртөмтгий болдог. Ялангуяа, аюулгүй байдал нь хангагдаагүй орон байранд амьдарч байгаа эмэгтэйчүүд бэлгийн болон бусад хэлбэрийн хүчирхийлэлд өртөх эрсдэл ихээхэн нэмэгддэг. Орон байрны нөхцөл нь шаардлага хангаагүй байх тусам эмэгтэйчүүдэд ирэх сөрөг нөлөө илүү байдаг. Жишээлбэл, ундны цэвэр ус авах нь ихэнхдээ эмэгтэйчүүдийн ажил байдаг. Хэрэв ундны ус, эрүүл ахуйн байгууламж нь шаардлагад нийцээгүй тохиолдолд тэд ундны усанд явах, дугаарлан зогсох, усаа зөөх зэрэгт өдөрт 4 хүртэлх цаг зарцуулдаг байна.

Гэр бүлийн хүчирхийлэл нь эмэгтэйчүүд, хүүхдийн хувьд орон гэргүй болох үндсэн шалтгааны нэг бөгөөд ялангуяа эрх зүйн зохицуулалт, хууль сахиулах байгууллагын хамгаалалт хангалтгүй байхад дээрх эрсдэл улам нэмэгддэг. Орон гэргүй болох эрсдэлээс айж эмээх нь эмэгтэйчүүдийг гэр бүлийн хүчирхийлэлтэй харилцааг хүлцэн тэвчихээс өөр аргагүй байдалд хүргэх нь бий.

---

<sup>11</sup> “Эдийн засаг, нийгмийн бодлого болон түүний эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлд нөлөөлөх нь” (E/CN.4/2000/68/Add.5).

## Б. Хүүхэд

Хүүхдийн эрүүл мэнд, боловсролын хөгжил, сайн сайхан амьдрал нь тэдний амьдарч байгаа орон байр, орчин нөхцөлөөс ихээхэн хамаардаг. Шаардлагад үл нийцсэн орон байр, албадан нүүлгэлт болон орон гэргүй болох зэрэг нь хүүхдийн өсөлт, хөгжилд сөргөөр нөлөөлөхийн зэрэгцээ сурч боловсрох, эрүүл мэндээ хамгаалуулах, аюулгүй орчинд амьдрах зэрэг олон эрх зөрчигдөхөд хүргэнэ.

### Хүүхдийн эрхийн тухай Конвенц

#### 16 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэг

Нэг ч хүүхдийн хувийн болон гэр бүлийн амьдрал, орон байрны халдашгүй байдал болон захидал харилцааны нууцад хөндлөнгөөс, хууль бусаар буюу дур мэдэн оролцох, эсхүл түүний нэр төр, алдар хүндэд хууль бусаар халдаж болохгүй.

#### 27 дугаар зүйл

1. Оролцогч улсууд бие бялдар, оюун ухаан, оюун санааны болон нийгмийн хөгжлийг хангах түвшинд аж төрөх хүүхэд бүрийн эрхийг хүлээн зөвшөөрнө.
2. Эцэг, эх буюу хүүхдийн төлөө үүрэг хариуцлага хүлээж байгаа бусад хүн хүүхдийг хөгжүүлэхэд шаардагдах амьдралын нөхцөлийг өөрсдийн чадавх, санхүүгийн боломжийн хэрээр хангах үндсэн үүрэг хүлээнэ.
3. Оролцогч улсууд энэхүү эрхийг хэрэгжүүлэхэд үндэсний нөхцөл, хөрөнгө бололцоондоо нийцүүлэн эцэг эх, хүүхдийн төлөө хариуцлага хүлээж буй бусад хүнд туслалцаа үзүүлэх арга хэмжээ авч, шаардлагатай тохиолдолд материаллаг тусламж, ялангуяа хувцас, орон сууцаар хангах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
4. [...]

НҮБ-ын Хүүхдийн Сан (UNICEF)-ийн 2005 оны *Дэлхийн хүүхдийн аж байдлын тайланд* дурдсанаар хөгжингүй улс орнуудад амьдарч буй гурван хүүхэд тутмын нэг нь буюу ойролцоогоор 640 сая орчим хүүхэд шаардлагад нийцсэн орон байранд амьдарч чадахгүй байна. Шаардлагад нийцэхгүй орон байр болон орон гэргүй байдлын хүүхдэд үзүүлэх сөрөг нөлөөллийг харгалзан үзэж НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хорооноос шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн түгээмэл шинж чанарыг онцлон, уг эрх нь хүүхэд бүрт ямар нэгэн ялгаварлал, хязгаарлалтгүйгээр хамааралтай болохыг онцлон тэмдэглэжээ.

Орон байр, хоргодох байр байхгүй, хүрэлцээгүй байдлыг хэдэн саяар тоологдох гудамжны хүүхдүүдээс төвөггүй харж болох бөгөөд олон хүчин зүйлээс хамааран орон байртай байх хүүхдийн эрх зөрчигдсөөр байна. Хэт дуу чимээтэй, зай талбайн хүрэлцээ муутай, хуучирч муудсан орон байрны нөхцөл нь хүүхдийн хөгжил, эрүүл мэнд болон сурч боловсрох, тоглож наадах боломжийг алдагдуулж байдаг. Шаардлагад нийцээгүй орон байрнаас үүдэн 5 хүртэлх насны хүүхдийн нас баралтын түвшин нэмэгддэг бөгөөд чанаргүй зуух болон шаардлага хангахгүй агааржуулалтаас үүдсэн гэр доторх агаарын бохирдол нь буурай болон хөгжиж байгаа улс орны хүүхдүүдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгааг олон тооны судалгаанаас харж болно.<sup>12</sup>

Ундны цэвэр ус болон ариун цэврийн байгууламж зэрэг орон байртай холбоотой үндсэн үйлчилгээгээр хангагдах нь хүүхдийн эрүүл мэндийг хамгаалахад чухал ач холбогдолтой. Жилд дунджаар 2 сая орчим хүүхэд суулгалт өвчнөөр нас барж байгаа бөгөөд тэдний 80-90 орчим хувь нь бохирдсон ус, шаардлагад нийцээгүй ариун цэврийн байгууламжаас шалтгаалж байна. Ялангуяа охидын хувьд, гэрийнхээ ойролцоох газраас ундны цэвэр ус авах боломжгүй байх нь холоос ус зөөхөд хүргэдэг. Хол зам туулах нь охидын сурч боловсроход сөргөөр нөлөөлөхийн зэрэгцээ хүчирхийлэл, аливаа халдлагад өртөх эрсдэлийг бий болгодог.

Хүүхдийн цэцэрлэг, сургууль, эрүүл мэндийн болон бусад үйлчилгээ авахад орон байрны байршил нь чухал нөлөөтэй. Хүүхэд сургуулиасаа хэт хол газарт амьдардаг, тээврийн хэрэгслээр явах боломжгүй, эсхүл тээвэр нь хэт өндөр үнэтэй байх зэрэг нь хүүхдийг боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээгээр хангагдахад сөргөөр нөлөөлнө.

Орон гэргүй байх нь хүүхдийн өсөлт, хөгжил, аюулгүй байдалд ноцтой үр дагавар учруулдаг. Орон гэргүй хүүхдүүд сэтгэл гутрал, нойргүйдэл, уур бухимдал, ганцаардал гэх зэрэг сэтгэл зүйн холбогдолтой олон тооны асуудалтай нүүр тулгардаг. Тогтсон хаягийн бүртгэлгүй байх нь тэдний хувьд эрүүл мэнд, боловсрол зэрэг үндсэн үйлчилгээгээр хангагдах боломжийг ихээр бууруулдаг. Гудамж талбайд ажиллаж, амьдарч байгаа хүүхдүүд энгийн иргэд болон цагдаа нарын албадлага, хүчирхийлэл, хүч хэрэглэсэн үйлдэлд өртөх нь түгээмэл байна.

<sup>12</sup> НҮБ-ын Хүүхдийн Сан, Ядуурал болон хот, суурин газарт амьдарч байгаа хүүхдүүдийг алагчилж байгаа нь” Инносенти Дайжест №. 10 (Флорэнц, 2002), хуудас 10.

Албадан нүүлгэлт нь гэр бүлийн гишүүн нэг бүрт сөргөөр нөлөөлөх хэдий ч хүүхдүүдэд ноцтой үр дагавар бий болгодог. Албадан нүүлгэн шилжүүлэлтэд өртсөний дараа гэр бүлийнх нь тогтвортой байдал сарниж, амьдрах орчин нөхцөл нь улам бүр доройтдог. Албадан нүүлгэлтийн үр дагавар нь хүүхдийн хөгжилд зэвсэгт мөргөлдөөнд нэрвэгдсэнтэй адилтгах үр дагаврыг бий болгодог.<sup>13</sup>

## **В. Ядуусын хорооллын оршин суугчид**

2008 оны эцсийн байдлаар дэлхийн нийт хүн амын тал нь хот, суурин газарт амьдарч байсан ч олонх нь шаардлагад нийцэхгүй дэд бүтэц, зохисгүй үйлчилгээтэй орчин нөхцөлд аж төрж байжээ. НҮБ-ын Хүн амын нутагшил, суурьшлын хөтөлбөр (Хабитат)-өөс нэг тэрбум ядуу хүн аюулгүй байдал нь хангагдаагүй ядуусын хороололд амьдарч байна гэж тэмдэглэсэн байна. Хөгжингүй улс орнуудын ядуусын хороололд амьдарч байгаа 930 гаруй сая ядуу иргэн хотын нийт хүн амын 42 хувийг эзэлж байна. Дээрх хувь хэмжээ Африкийн Сахар орчмын бүс нутагт харьцангуй өндөр буюу хотын нийт хүн амын 72 хувийг эзэлж байгаа бол Зүүн Азийн улс орнуудад 59 орчим хувьтай байна.

Ядуусын хороолол бол удаан хугацаанд амьдран суухад бэрхшээлтэй, амьдрах хангалттай зай талбай хүрэлцээгүй, цэвэр ус болон шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар хомс газар юм. Албан бус суурин болох ядуусын хорооллын оршин суугчид эзэмшлийн аюулгүй байдлын хамгаалалтгүйгээс албадан нүүлгэлт, заналхийлэл болон бусад төрлийн хүчирхийлэлд өртөх эрсдэл ихтэй байдаг. Жил бүр 2 сая орчим хүн албадан нүүлгэлтэд өртөж байгаагаас дийлэнх нь ядуусын хорооллын иргэд байдаг хэмээн НҮБ-ын Хабитатын тайланд дурджээ. Албадан нүүлгэлт нь ядуусын хороололд оршин суугаа иргэдийг орон гэргүй болгоод зогсохгүй улам бүр ядууралд нэрвэгдэхэд хүргэдэг.

Албан бус суурин гэдэг нэршил нь үндэсний болон орон нутгийн төрийн байгууллагаас иргэдэд хүргэх үндсэн тусламж, үйлчилгээг үзүүлэх чиг үүрэгтэй хайнга хандах шалтгаан болж байна. Үүний үр дүнд ядуусын хорооллын иргэд ундны цэвэр ус болон шаардлагад

---

<sup>13</sup> Т.Рахматулах, *Нүүлгэн шилжүүлэлтийн хүүхдэд нөлөөлөх үр дагавар: Фном Пэнх, Манила болон Мумбайн тохиолдлыг шинжлэн судлах нь*” (Нью Йорк, НҮБ-ын Ази, Номхон далайн бүс нутгийн Эдийн засаг, нийгмийн Комисс болон Орон байртай байх эрхийн талаарх Азийн Эвсэл, 1997 он).

нийцсэн ариун цэврийн байгууламж бараг байхгүй, цахилгаан, хог хаягдал зайлуулах үйлчилгээ хомс эсхүл байхгүй нөхцөлд амьдарч байна. Ядуусын хороолол нь цэвэр усны системд холбогдоогүй учир ядуу иргэд хотын орлого өндөр иргэдтэй харьцуулахад цэвэр усны төлбөрт 5-10 дахин өндөр үнэ төлж байна.<sup>14</sup>

Ядуусын хорооллын орчин, нөхцөлийг сайжруулах нь ядуу иргэдийн орон байрны нөхцөлийг дээшлүүлэх үр нөлөөтэй арга юм. Дэлхийн Банк болон НҮБ-ын Хабитатаас Дэлхийн Хотын Холбоог 1999 онд үүсгэн байгуулсан. Тус холбооноос үзэж байгаагаар ядуусын хорооллын орчин нөхцөлийг сайжруулна гэдгийг “нийгэм, эдийн засаг, зохион байгуулалт болон хүрээлэн буй орчны нөхцөлийг сайжруулах үйл явц нь орон нутгийн иргэд, нийгмийн бүлгүүд, бизнесийн болон орон нутгийн төрийн байгууллага хоорондын хамтын үйл ажиллагааны хүчин чармайлтын үр дүнд бий болно”<sup>15</sup> гэж тодорхойлжээ. Ядуусын хорооллыг хөгжүүлж, орчин нөхцөлийг сайжруулах хөтөлбөрүүд нь тэнд оршин суугаа бүхий л иргэдийн эзэмшлийн аюулгүй байдлыг баталгаажуулж, эмэгтэйчүүдийн эрхийг тусгайлан авч үзэж, өмч хөрөнгийн харилцаанд эрх тэгш байдлыг бий болгож, нөлөөлөлд өртөх иргэдийн бодитой оролцоог хангасан тохиолдолд шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хэрэгжүүлэхэд чухал хувь нэмрээ оруулах болно.

## **Г. Орон гэргүй хүмүүс**

Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч орон гэргүй, тэнүүлч байдал нь “шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хүндэтгэхгүй байгааг илтгэн харуулах илэрхий шинж юм” хэмээн онцлон тэмдэглэсэн байна.

Орон гэргүй байх ойлголтыг олон улсын түвшинд хараахан нэг мөр тодорхойлж чадаагүй байгаа хэдий ч өргөн болон явцуу хүрээний тодорхойлолтууд байна. Явцуу хүрээнд авч үзвэл орон гэргүй байна гэдэг нь “толгой хорогдох орон гэргүй байх” ойлголт юм. Харин өргөн хүрээнд авч үзвэл орон гэргүй байх нь толгой хорогдох орон гэргүй

<sup>14</sup> НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, *Хүний Хөгжлийн Тайлан 2006, Хомсдол: Эрх мэдэл, Ядуурал болон Дэлхийн усны хомсдол* (Нью Йорк, 2006), 52-53 дахь хуудас.

<sup>15</sup> Дэлхийн Банк, НҮБ-ын Хабитат, *Ядуусын хороололгүй хотын төлөөх Хотын Холбоо: Ядуусын хорооллыг Хөгжүүлэх Үйл ажиллагааны Хөтөлбөр, Тусгай хэвлэл* (1999), хуудас 2 (дэлгэрэнгүйг сайтаас уншина уу: [www.citiesalliance.org](http://www.citiesalliance.org)).



байх ойлголтоос гадна орон гэргүй болох эрсдэл болон уг нөхцөл байдлаас гаргахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах хугацааг хамруулж ойлгож болно. Харин статистикийн тоо мэдээ боловсруулахад ашиглах зорилгоор НҮБ-аас орон гэргүй өрх гэсэн ойлголтыг дараах байдлаар тодорхойлжээ. “Орон гэргүй өрх гэдэг нь амьдран суух зориулалттай орон байранд амьдардаггүй өрх юм. Тэд цөөн тооны эд хогшлоо өөртөө авч явах бөгөөд гудамж талбай, барилгын үүд хаалга гэх зэрэг газарт хоног төөрүүлэн амьдардаг”.<sup>16</sup> Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч орон гэргүй гэх ойлголтыг хэт явцуу хүрээнд тодорхойлж байгааг шүүмжилж, нийгмээс гадуурхагдах нь орон гэргүй иргэдэд тулгардаг бэрхшээл хэмээн нийтлэг байдлаар тодорхойлж байгаа хөгжингүй улс орнуудын туршлагыг тэмдэглэжээ. НҮБ-ын Хабитат орон гэргүй байх ойлголтыг зөвхөн унтах, хоног төөрүүлэх газаргүй байх гэсэн хэт өрөөсгөл байдлаар тодорхойлж болохгүй харин тогтсон хаяг, хамааралгүй байх гэсэн өргөн агуулгаар харах ёстойг онцлон тэмдэглэжээ. Дэлхийн түвшинд орон гэргүй байх ойлголтыг нэг мөр тодорхойлоогүйгээс уг үзэгдлийн нийгмийн тархацын хүрээг тодорхойлоход шаардлагатай тоо мэдээ хязгаарлагдмал байгаа зэрэг нь орон гэргүй болохоос урьдчилан сэргийлэх, таслан зогсоох үр нөлөөтэй стратеги, бодлого боловсруулахад саад болсоор байна.

Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгчийн онцлон тэмдэглэснээр ядуурал бол орон гэргүй болох нөхцөлийг бүрдүүлж байгаа үндсэн шалтгааны нэг юм. Ажилгүйдэл, нийгмийн хамгааллын тогтолцооны хангалтгүй байдал, орон байрны хэт өндөр үнэ, албадан нүүлгэлт, нийгмийн халамжийн хүрээнд олгодог нийтийн орон сууцны хүртээмжгүй байдал, мөргөлдөөн, байгалийн гамшиг болон нийгмийн эмзэг бүлгийн хэрэгцээ, шаардлагыг чухалчлан авч үзэхгүй байх зэрэг нь хүмүүсийг орон гэргүй болох эрсдэлийг нэмэгдүүлдэг бусад хүчин зүйл юм.

1960-1970-аад онд дэлхийн олон улс оронд сэтгэцийн эрүүл мэндийн эмнэлгүүдээс өвчтөнүүдийг гаргаж тухайн харьяа газрынх нь сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ, хяналт, тусламжид найдан орхисон нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орон гэргүй байдал өсч нэмэгдэхэд хүргэсэн.

<sup>16</sup> *Хүн ам болон орон сууцны тооллогын зарчим, зөвлөмж* (НҮБ-ын хэвлэл, Худалдааны №. 07.XVII.8 P) 1.328 догол мөр

Орон гэргүй хүмүүсийн шаардлагад нийцсэн орон байртай байх эрх төдийгүй бусад олон эрх нь ноцтой зөрчигддөг. Орон гэргүй байдалд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, тэнүүчлэн хүнд нөхцөлд хоног төөрүүлэх, гудамж талбайгаас орон гэргүй хүмүүсийг хөөн зайлуулах ажиллагаа зэрэг нь орон гэргүй хүмүүсийн бие махбод, сэтгэл санаанд шууд сөргөөр нөлөөлдөг. Халдашгүй байдал, амьдрах орчны аюулгүй байдал хангагдаагүй орон гэргүй иргэд нь хүчирхийлэл, заналхийлэл, дарамтад өртөх эрсдэл илүү байдаг.

Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг бүрэн хэрэгжүүлэхийн тулд орон гэргүй болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх нь төрийн үүрэг хариуцлага юм. Орон гэргүй байх ойлголтын цар хүрээ болон орон гэргүй хүмүүстэй өргөн хүрээнд бодитоор зөвлөлдөх ёстойг тусгасан үндэсний орон байрны стратегитэй болохыг Ерөнхий Зөвлөмж № 4 (10-13 дугаар догол)-т нэн даруй авч хэрэгжүүлэх үйл ажиллагаануудын нэг нь гэж тайлбарласан байдаг. Ерөнхий Зөвлөмж № 7 (17 дахь догол)-д албадан нүүлгэлтээс үүдэн нэг ч хүн орон гэргүй болох ёсгүй хэмээн тайлбарлажээ.

#### **Д. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс**

Дэлхийн даяар 650 гаруй сая хөгжлийн бэрхшээлтэй хүн амьдарч байгаа бөгөөд тэдний 80 орчим хувь нь хөгжингүй улс орнуудад аж төрж байна. Тэр хүмүүс шаардлагад нийцсэн орон байртай байх эрхээ эдэлж, хэрэгжүүлэхэд цөөнгүй бэрхшээлтэй тулгардаг. Үүнд: хөдөлгөөний хязгаарагдмал байдал, ялгаварлан гадуурхалт, алагчлал, хөдөлмөрийн зах зээлд нэвтрэх боломж хязгаарлагдмал байх, бага орлого, халамжийн нийтийн байр болон нийгмийн тусламж дэмжлэг хангалтгүй байх зэргийг нэрлэж болно.

Хүртээмжтэй байдал бол чухалчлан үзэх үндсэн асуудал юм. Орон байр, орон байртай холбоотой байгууламж, орчин нөхцөл зэргийг ихэвчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулан төлөвлөсөн байдаг. Орон сууц болон орчны байгууламжийг шинээр барьж байгуулах, ядуусын хорооллыг дахин төлөвлөх, сайжруулах зэрэг үйл явцад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг оролцуулах, тэдэнтэй бодитоор зөвлөлдөх боломжоор хангадаггүй зэрэг нь тэднийг ялгаварлан гадуурхах нийгэмд хэвшин тогтсон хандлагын илрэл юм. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд нь хүний эрхийн зөрчилд өртөх өндөр эрсдэлтэйд тооцогддог. Тухайлбал, албан бус суурьшлын ариун цэврийн

байгууламж нь тэдэнд тулгардаг хэцүү бэрхшээлүүдийн нэг юм.

Эзэмшлийн аюулгүй байдал нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, нэн ялангуяа оюуны болон сэтгэцийн бэрхшээлтэй хүмүүст тулгардаг өөр нэгэн тулгамдсан асуудал юм. Тэд эрх зүйн чадамжаа бүрэн мэддэггүйн зэрэгцээ өргөдлөө биеэр гаргах шаардлагатай тулгардаг зэрэг нь тэднийг орон байртай холбоотой аливаа албан ёсны гэрээ, хэлэлцээр (түрээслэх, өмчлөх гэх мэт) хийх бараг боломжгүй болгодог. Иймээс хөгжлийн бэрхшээлтэй иргэд орон байраар хангагдахын тулд илүү албан бус арга замыг сонгоход хүрдэг байна. Улмаар энэ байдал нь эргээд тэднийг албадан нүүлгэлтэд өртөх эрсдэлд оруулдаг байна.

Ерөнхийдөө, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг алагчилж, шударга бусаар харьцаж байгааг шийдвэрлээгүй, нийгмийн болон олон нийтийн үйлчилгээ, тэр дундаа нийгмийн хамгааллын нийтийн орон байраар хангах зэрэг үйлчилгээ байхгүй нөхцөлд тэд ялгаварлан гадуурхалтад өртсөөр байх болно. Энэ нь эцэстээ тэднийг албадан нүүлгэлт, орон гэргүй болох болон шаардлагад үл нийцсэн орон байранд амьдрах зэрэг эрсдэлд илүү өртөмтгий болгодог.

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

**Хөгжлийн бэрхшээлтэй Хүмүүсийн эрхийн тухай** конвенцид заасны дагуу оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүн бүр шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг оролцуулан хүний бүхий л эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлэх явдлыг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжих үүрэгтэй.

**1 дүгээр зүйлд** зааснаар оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нэр төр, эрхэм чанарыг хүндэтгэн дэмжинэ.

**9 дүгээр зүйлд** зааснаар оролцогч улс орнууд нь хүртээмжтэй байдал, нэн ялангуяа барилга, орон сууцтай холбоотой тулгарч буй саад, бэрхшээлийг тодорхойлж, устгахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй.

**12 дугаар зүйлд** оролцогч улсууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс амьдралын бүхий л хүрээнд бусадтай адил тэгш байх үндсэн дээр эрх зүйн чадамжтай байх явдлыг хүлээн зөвшөөрөх бөгөөд эрх зүйн чадамжаа хэрэгжүүлэхэд нь шаардагдах дэмжлэг туслалцааг хүртээмжтэй байлгах үүднээс шаардлагатай арга хэмжээ авна.

**28 дугаар зүйлд** хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдгээрийн гэр бүл шаардлагад нийцсэн орон байрыг оролцуулаад амьдралын хүрэлцэхүйц түвшинд аж төрөх эрхийг баталгаажуулсан бөгөөд бүх нийтийг орон сууцаар хангах хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулах зэргээр хөгжлийн бэрхшээлээс шалтгаалсан аливаа алагчлалгүйгээр дээрх эрхийг хэрэгжүүлэх явдлыг дэмжих, хамгаалахад чиглэсэн шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр заасан.

Ерөнхий Зөвлөмж №4-т хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь шаардлагад нийцсэн орон байрны нөөцөөс бүрэн дүүрэн, тогтвортой хүртэх ёстой бөгөөд орон сууцны холбогдох хууль, бодлого нь тэдний онцгой хэрэгцээг тухайлан авч үзсэн байх шаардлагатай гэж тайлбарласан. Эдийн Засаг, Нийгэм, Соёлын эрхийн Хорооны гаргасан Ерөнхий Зөвлөмж №5 (1994)-д шаардлагад нийцсэн орон байртай байх эрх нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байхыг дахин баталгаажуулжээ. Түүнчлэн, шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгчийн үзсэнээр орон сууц нь хийц болон эдийн засгийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байхын зэрэгцээ амьдарч буй орчиндоо нийгмийн харилцаанд үр нөлөөтэй оролцох нөхцөлийг хангасан байх шаардлагатай гэжээ.

## **Е. Шилжин суурьшигч болон цагаачид**

Дүрвэгч, орогнол хүсэгч, дотоодын шилжин суурьшигч болон цагаач гэх зэрэг шилжин суурьшиж буй хүн бүр шаардлагад нийцсэн орон байртай байх эрх болон бусад эрх, эрх чөлөө нь зөрчигдөж болзошгүй нийгмийн эрсдэлтэй бүлэгт хамаардаг.

Шилжин суурьшигчид нь ялгаварлан гадуурхалт, арьс үндсээр алагчлах болон хэт үндсэрхэг үзэлд өртөх эрсдэлтэй бөгөөд энэ нь тэдний аюулгүй, тогтвортой, шаардлагад нийцсэн амьдралын орчин нөхцөлөө бүрдүүлэхэд нь саад болж болзошгүй юм. Албадан нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн хүмүүс дүрвэж, зугатах явцдаа сэтгэл санаа, бие махбодын гэмтэл, шарх авсан байх нь түгээмэл бөгөөд аливаа нөхцөл байдалд дасан зохицох стратеги, дэмжлэг авах арга механизмаа гээсэн байдаг.

Дэлхийн улс орнуудын дүрвэгсдийн болон дотоодын шилжин суурьшигчдын хуарангууд нь дүүрч, ачаалал хэтэрсэн үед шаардлагад нийцсэн хамгаалалт, үйлчилгээг шилжин суурьшигчдад үзүүлэх боломжгүй болдог. Зарим тохиолдолд тухайн хуаранд орогнож байгаа хүмүүс наад захын үндсэн үйлчилгээ хүртэж чаддаггүй. Хэрэв хуарангийн бүтэц, зохион байгуулалтыг бий болгохдоо эмэгтэйчүүд, хүүхдүүд зэрэг нийгмийн эрсдэлтэй бүлгийн эрх ашгийг онцгойлон анхаарч үзээгүй тохиолдолд тэнд байрлаж буй охид, эмэгтэйчүүд бэлгийн болон жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогч болох эрсдэлтэй юм.

Харин хот, суурин газарт амьдарч байгаа дүрвэгсэд, орогнол хүсэгч болон дотоодын шилжин суурьшигчдын нөхцөл байдал харьцангуй сайн байх боломжтой ч тэдний эрх зүйн байдал нь нийгмийн харилцаанд бүрэн оролцох боломжийг хязгаарладаг. Тиймээс тэд шаардлагад нийцсэн орон байр түрээслэж чаддаггүй тул аюулгүй байдал нь хангагдаагүй орчин нөхцөлд олуулаа амьдрахад хүрдэг. Түүнчлэн, хот суурин болон хөдөө орон нутагт амьдарч байгаа цагаачид аюулгүй байдал нь хангагдаагүй орчин нөхцөлд аж төрж байна. Хөдөлмөр эрхэлж байгаа дотоодын цагаачид болон үйлдвэрийн ажилчдын хувьд ажил олгогч нь тэднийг ажлын байрандаа амьдрах боломж олгож болох юм. Гэвч тэдний олонх нь ариун цэврийн шаардлага хангаагүй, ээлжээр унтдаг, ачаалал нь хэтэрсэн ажилчдын байранд амьдардаг байна. Дотоодын ажилчид агааржуулалт муутай

өрөө, агуулах болон нийтийн өрөө зэрэг хүний эрхэм чанар, хувийн нууц, аюулгүй байдал нь хангагдаагүй орчин нөхцөлд амьдрахаас аргагүй байдалд хүрдэг байна.

Албан бус буюу бичиг баримтгүй цагаачид, тухайлбал, татгалзсан хариу авсан орогнол хүсэгчдийн хувьд шаардлагад нийцсэн орон байртай байх эрх төдийгүй өөр хэд хэдэн эрх ноцтой зөрчигдөх эрсдэлтэй тулгардаг байна. Албан бус цагаачид ихэвчлэн орон гэргүй байдаг тул түрээсийн төлбөрөө төлөх чадваргүй болох үедээ ихэвчлэн нэн даруй байрнаасаа хөөгдөхөд хүрдэг байна.

Эрх зүйн байдал нь хуулиар хамгаалагдаагүй, түүнчлэн албан бусаар буюу хууль бусаар цагаачлах үйлдлийг дэлхийн олон оронд гэмт хэрэгт тооцох болсноос үүдэн цагаач хүмүүсийн олонх нь алагчлал, ялгаварлан гадуурхалтад өртөх, түрээсийн харилцаанд эрх нь зөрчигдөх, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх боломжгүй болж байна. Үндэсний орон сууцны хөтөлбөр, стратеги нь цагаач хүмүүс, тэр дундаа албан бус цагаачдын асуудлыг огт тусгадаггүй ажээ.

Урт хугацааны шийдлийн хүрээнд дүрвэгсэд болон шилжин суурьшигч нарт санал болгож байгаа орон байр болон эд хөрөнгийг нөхөн сэргээх тухай зохицуулалт нь сайн дурын үндсэн дээр нутаг буцах шийдвэр гаргасан дүрвэгсэд, дотоодын шилжин суурьшигчдын эрхийн баталгааг хангах чухал дэмжлэг болж байна. Сүүлийн жилүүдэд сайн дурын үндсэн дээр нутаг буцах тухай ойлголт нь дүрвэгсдийн хувьд зүгээр нэг улс орондоо буцах, эсхүл дотоодын шилжин суурьшигчдын хувьд зүгээр нэг төрөлх хот, бүс нутагтаа буцахаас илүү өргөн хүрээтэй ойлголт болоод байна. Энэ нь тэд эргэн ирж өөрийн хөрөнгө, газар, орон сууцаа дахин ашиглаж, эзэмшлийн хяналтаа тогтооно гэсэн үг юм. Нутаг буцах шийдвэр гаргаагүй дүрвэгсэд болон дотоодын шилжин суурьшигчдыг албадан нутаг буцаах явдлаас бүхий л тохиолдолд хамгаалах ёстой бөгөөд шаардлагад нийцсэн орон байртай байх эрх нь хангагдахуйц орчин нөхцөлийг бий болгосон тохиолдолд нүүлгэн шилжүүлнэ.

ОН-ИМН  
СУДАЛГААНЫ САН

**Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай Конвенцийн** дагуу оролцогч улсууд нь орон байртай холбоотой асуудлаар дүрвэгсдэд боломжийн хэрээр аль болох таатай нөхцөл олгох үүрэгтэй бөгөөд энэ нь ерөнхийдөө ижил нөхцөл байдалтай гадаадын иргэдийнхээс дордуулж болохгүй болно. (21 дүгээр зүйл)

**Цагаач ажилчид ба тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн эрхийг хамгаалах тухай олон улсын Конвенцийн** 43 дугаар зүйлд орон байр олж авах харилцаанд эрх тэгш хандах болон албан ёсны цагаач хүмүүс, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийг түрээсийн мөлжлөгөөс хамгаалах баталгааг зохицуулсан.

**Хөдөлмөрийн цагаач иргэдийн эрхийн талаарх ОУХБ-ын 97 дугаар Конвенцид (дахин шинэчлэгдсэн) (1949)** цагаач ажилчдын орон байрны асуудлыг авч үзсэн.

Ерөнхий Нарийн Бичгийн Дарга Нарын Газрын Дотоодын шилжин суурьшигчдын асуудал эрхэлсэн төлөөлөгчийн баталсан **Дотоодын шилжин суурьшигчдын талаар баримтлах зарчмууд** нь дотоодын шилжин суурьшигч хүн бүр аливаа нөхцөл байдлаас үл хамааран, ялгаварлан гадуурхалтаас ангид орчинд амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх эрхтэй болохыг дахин баталгаажуулсан бөгөөд холбогдох төрийн байгууллагууд нь тэдний орон байрны аюулгүй байдлыг хангах шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй байхаар заасан. (18 дугаар зарчим)

**Арьс үндсээр алагчлах үзлийг устгах Хорооноос гаргасан Ерөнхий Зөвлөмж №30 (2004)**-д оролцогч улсуудын “иргэн болон харьяалалгүй хүмүүсийн шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хэрэгжүүлэх эрх тэгш баталгааг бүрдүүлэх бөгөөд орон сууцны агентлагууд ялгаварлан гадуурхах үйлдэл хийхгүй байх баталгааг хангах болон орон байрны харилцаанд алагчлах явдлаас урьдчилан сэргийлэх”-ийг уриалсан байдаг.

Ийнхүү орон байр болон бусад хөрөнгийг нөхөн сэргээх асуудлыг хүний эрх хэмээн олон улсын, бүс нутгийн болон үндэсний хууль тогтоомжоор хүлээн зөвшөөрөх нь улам бүр нэмэгдсээр байна. НҮБ-ын Хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих Дэд Хорооноос 2005 оны 8 дугаар сард “Пинейрогийн Зарчим” буюу Дүрвэгсэд болон шилжин суурьшигчдын орон байр болон эд хөрөнгийг нөхөн сэргээх тухай зарчмуудыг баталсан. Эдгээр зарчим нь орон байр болон эд хөрөнгийг нөхөн сэргээлгэх эрхийг бодитоор хэрэгжүүлэх, энэ талаарх

холбогдох хууль тогтоомж, хөтөлбөр, бодлогын баримт бичгийг олон улсын хүний эрх, хүмүүнлэгийн эрх зүйн болон үндэсний стандартад нийцүүлэн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд баримтлах бодлогын удирдамж болно.<sup>17</sup>

## **Ё. Уугуул иргэд**

Уугуул иргэд нь нийгмийн бусад бүлгүүдтэй харьцуулахад ихэвчлэн шаардлагад нийцээгүй орон байранд амьдардаг бөгөөд орон сууцны зах зээлийн харилцаанд тогтолцооны шинжтэй ялгаварлан гадуурхалтад илүүтэй өртөх эрсдэлтэй байдаг.<sup>18</sup> Нийгмийн үндсэн үйлчилгээ хүртэх боломж хангалтгүй, уламжлагдан ирсэн газар нутгийн эзэмшлийн аюулгүй байдал нь хамгаалагдаагүй байх, нүүн шилжих эрсдэлт нөхцөлд амьдрах, төрөөс санал болгож буй төсөл хөтөлбөр нь ахуй, соёлын онцлогт нь нийцэхгүй байх зэрэг уугуул иргэдийн орон байрны тааруу нөхцөл байдал нь (ялангуяа, ихэнх хүн амтай харьцуулахад) тэдний санааг зовоосон асуудал нь юм. Уугуул иргэд нь орон байртай холбоотой бараг бүхий л харилцаанд ялгаварлан гадуурхагдаж байдаг. Тухайлбал, тэдний онцгой хэрэгцээ шаардлагыг анхаарч үзээгүй ялгаварлан гадуурхалтыг нөхцөлдүүлсэн хууль тогтоомж, бодлого; орон сууц олж авах санхүүгийн эх үүсвэр буюу зээлийн харилцаа, орон сууцны хуваарьлалт болон түрээсийн харилцаанд газар өмчлөгчдийн зүгээс ирэх аливаа ялгаварлан гадуурхалт зэргийг нэрлэж болно.

Дэлхийн өнцөг булан бүрт амьдарч байгаа уугуул иргэдийн олонх нь хөдөө, орон нутагт амьдарсаар байгаа хэдий ч сайн дурын үндсэн дээр болон аливаа албадлагаас үүдэн уламжлалт газар, нутгаа, амьдралын эх үүсвэрээ орхин хот, суурин газарт нүүн шилжих үзэгдэл ихсэж байна. Харамсалтай нь тэдний ихэнх нь ядууралд өртдөг. Үүнээс үүдэн хот, суурин газарт амьдарч байгаа уугуул иргэдийн орон байрны нөхцөл нь ихэнх тохиолдолд зохих шаардлагад нийцдэггүй. Ядуу, тааруу орон байранд амьдрах ачааны хүндийг уугуул эмэгтэйчүүд үүрч байна.

<sup>17</sup> Эх нутаг руугаа буцаж байгаа дүрвэгсэд болон дотоодын нүүн шилжигчдэд олгох орон байр болон хөрөнгийн нөхөн сэргээлт: Тусгай илтгэгчийн тайлан, Paulo Sérgio Pinheiro” (E/CN.4/ Sub.2/2005/17), түүнчлэн НҮБ-ын Хүнс, Хөдөө аж ахуйн байгууллагын бусад байгууллагуудтай хамтран боловсруулсан, *Дүрвэгсэд болон дотоодын нүүн шилжигч нарт олгох орон байр болон хөрөнгийн нөхөн сэргээлтийн талаарх Гарын авлага: “Пинеирогийн зарчим”-ыг хэрэгжүүлэх нь* (2007).

<sup>18</sup> НҮБ-ын Орон байртай байх Хөтөлбөр, “Тайлан №7: Уугуул иргэдийн шаардлагад нийцсэн орон байртай байх эрх. Дэлхийн тойм” (2005).



Зарим улсад уугуул иргэдийн талаас илүү хувь нь хот, суурин газарт амьдарч байгаа бөгөөд тэдний шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хэрхэн хангаж, хамгаалах асуудал төр, засгийн газрын хувьд шинэ сорилт болж байна.<sup>19</sup>

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пактын 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт шаардлагад нийцсэн орон байртай байх эрх нь хүн бүрт хамааралтай болохыг баталгаажуулсан. Түүнчлэн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт пактаар хамгаалагдсан бүхий л эрхийг хүн бүр ямар нэгэн алагчлалгүйгээр эдлэх эрхтэй байхаар заасан. Дээрх зохицуулалт нь уугуул иргэд шаардлагад нийцсэн орон байртай байх эрхээ аливаа ялгаваргүйгээр нийгмийн олонх гишүүдийн нэгэн адил тэгш байдлаар хэрэгжүүлэх эрхийг баталгаажуулсан болохыг харуулж байна.



---

<sup>19</sup> НҮБ-Хабитат, *Хот, суурин газарт амьдарч байгаа уугуул иргэдийн орон сууц: Хот суурин газарт амьдарч байгаа уугуул иргэдийн орон сууцны талаар баримтлах Бодлогын Гарын авлага, Уугуул иргэдийн Хотын бодлогын гарын авлага* (Найроби, 2009).

**Уугуул иргэдийн эрхийг хамгаалах НҮБ-ын Тунхаглал (2007)** нь уугуул иргэдийн оршин тогтнох, сайн сайхан амьдрах, нэр төртэй байх эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжихэд чиглэсэн олон улсын хэмжээнд баримтлах наад захын жишиг, хэм хэмжээг тогтоосон байдаг. Дээрх тунхаглалд шаардлагад нийцсэн орон байртай байх эрхтэй хамааралтай өөрийгөө тодорхойлох эрх, газар, нутаг дэвсгэр болон түүний баялагтай холбоотой эрх, нийгэм, эдийн засгийн эрх болон ялгаварлан гадуурхалтаас ангид байх зэрэг эрхүүдийг баталгаажуулсан. Уугуул иргэдийн өөрийгөө тодорхойлох эрх, газар, нутаг дэвсгэр болон түүний баялагтай холбоотой эрхийн зөрчил нь ихэвчлэн шаардлагад нийцсэн орон байртай байх эрх зөрчигдөхөд хүргэдэг. Тунхаглалын 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт орон байрны нөхцөлөө сайжруулах эрхийг хамгаалсан. Түүнчлэн, орон байртай холбоотой хөтөлбөр, бодлого, орон байрны асуудал эрхлэх байгууллагаа уугуул иргэд өөрсдөө тодорхойлох эрхийн ач холбогдлыг Тунхаглалд тусгасан.

**Арьс үндсээр алагчлах үзлийг устгах Хорооноос** гаргасан Ерөнхий Зөвлөмж № 23-т уугуул иргэдийг ялгаварлан гадуурхахыг эрс хориглосон бөгөөд тэдний суурьшиж, ашиглаж ирсэн газар, нутаг, баялгаа өмчлөх, хөгжүүлэх, эрхлэн удирдах, ашиглах эрхийг нь хүлээн зөвшөөрч, хамгаалах, хэрэв тэдний үе уламжлан өмчилж, суурьшиж, ашиглаж ирсэн газрыг тэдний зөвшөөрөлгүйгээр, тэдэнд бүрэн мэдээлэл өгөхгүйгээр авсан бол тухайн газар нутгийг эргүүлэн өгөх алхам хийхийг оролцогч улс улсуудад уриалсан байдаг.

**Бие даасан улс орнууд дахь Уугуул иргэд болон омгийн хүмүүсийн эрхийн талаарх ОУХБ-ын 169 дүгээр конвенци** (1989)-д хөдөлмөр эрхлэгч уугуул иргэдийг орон байрны хувьд ялгаварлан гадуурхахыг хориглосон байдаг. (20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн (с) заалт)

UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

### III. УЛС ОРНУУД БОЛОН БУСАД ХОЛБОГДОХ ТАЛУУДЫН ҮҮРЭГ

Улс орнууд нь хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих үндсэн үүрэг хүлээдэг. Хүний эрхийг хамгаалах үүрэг нь олон улсын заншлын хэм хэмжээ (хууль зүйн үүргийн шинжийг бий болгосон хууль зүйн хувьд улс орнууд хүлээн зөвшөөрч, дагаж биелүүлэх ерөнхий практик) болон нэгдэн орсон улсууд заавал биелүүлэх шинжтэй хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцоор тус тус тодорхойлогддог.

#### A. Нийтлэг үүрэг

Нэгдэн орж, соёрхон баталсан хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх нь улс орнуудын олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг билээ. Зарим үүрэг нь нэн даруй хэрэгжүүлэх утга агуулдаг бөгөөд тухайлбал, үл ялгаварлах үндсэн дээр шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хэрэгжүүлэх баталгааг бий болгох үүрэг нэн даруй хэрэгжих шинжтэй юм.

Харин Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пактын дагуу оролцогч улсууд нь шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг бүрэн хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлэх үүрэгтэй. Өөрөөр хэлбэл, дээрх Пактаар хүний эрхийг хамгаалах үүргээ биелүүлэх нөөцийн хувьд улс орнууд хязгаарлагдмал байдаг бөгөөд хүн бүрийн шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хэрэгжүүлэхэд цаг хугацаа шаардагдах болохыг хүлээн зөвшөөрсөн. Тиймээс шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн зарим бүрэлдэхүүн хэсгийг *дэвшилттэйгээр хэрэгжүүлэх боломжтой* гэж үздэг бол үл алагчлах, үл ялгаварлан гадуурхах талаар хүлээсэн үүрэг нь *нэн даруй хэрэгжүүлэх* үүрэгт ордог.

#### **Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт, 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг**

Оролцогч улс бүр дангаараа болон олон улсын тусламж, хамтын ажиллагаагаар, тухайлбал эдийн засаг, техникийн салбарт, энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг бүрэн хэрэгжүүлэхийг дэвшилттэйгээр хангахын тулд хууль тогтоомжийн арга хэмжээг оролцуулан, зохистой арга хэмжээг бүх боломжийнхоо хэрээр авах үүрэгтэй.

Орон байртай байх эрхийг бүхий л агуулгаар нь нэн даруй хэрэгжүүлэх боломжгүй хэдий ч улс орнууд нь хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжихийн тулд шаардлагатай бүхий л арга хэмжээг өөрийн нөөц бололцоондоо тулгуурлан авч хэрэгжүүлсэн болохоо харуулах ёстой. Нөөцийн асуудлыг тухайн улс дотоод эх үүсвэрээрээ болон Пактын 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг болон 23 дугаар зүйлд тус тус зааснаар олон улсын тусламж, хамтын ажиллагааны дэмжлэгтэйгээр шийдвэрлэж болно.

Пактын 3 дугаар зүйлд оролцогч улс бүр эдийн засаг, нийгэм, соёлын бүх эрхийг эрэгтэй, эмэгтэйчүүдэд тэгш эдлүүлэх нөхцөлийг хангах үүрэгтэй хэмээн заасан.

**Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт, 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг**

Оролцогч улсууд арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, төрсөн болон бусад нөхцөл байдлаар алагчлахгүйгээр энэхүү Пактад тунхагласан эрхийг хэрэгжүүлэх баталгааг бий болгох үүрэгтэй.

Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг бүрэн хэрэгжүүлэхийн тулд улс орнууд тодорхой, төлөвлөсөн, зорилтод үйл ажиллагааг нэн даруй авч хэрэгжүүлэх үүрэгтэй. Бүх улс орон уг эрхийг хамгийн наад захын түвшинд хэрэгжүүлэх баталгааг бүрдүүлэх шаардлагатай. Тухайлбал, иргэдийг үндсэн сууц буюу орон байрнаас нь салгаж, орон гэргүй болгохгүй байх баталгааг бий болгох үүрэгтэй. Хэрэв тухайн улс дээрх үүргээ биелүүлэх боломжгүй бол уг эрхийг хамгийн наад захын түвшинд хэрэгжүүлэхийн тулд боломжит бүхий л нөөцийг ашиглан хүчин чармайлт гаргасан болохоо нотлон харуулах ёстой. Үүний нэгэн адил, улс орнууд шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн хамгаалалтыг сулруулж, ухрах арга хэмжээ авч хэрэгжүүлэх тохиолдолд асуудлыг шийдвэрлэх бүх хувилбарыг нягт нямбай судалсан бөгөөд хүний эрхэд үзүүлэх үр нөлөөг тооцож, бүхий л боломжит нөөцийг бүрэн ашигласан болохоо танилцуулах үүрэгтэй. Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хэрэгжүүлэх арга хэрэгсэл нь улс бүрийн онцлогоос хамааран харилцан адилгүй байдаг тул олон улсын гэрээгээр улс орнуудад ямар нэгэн тухайлсан аргыг санал болгодоггүй. Харин уг эрхийг бүрэн хэрэгжүүлэхийн тулд улс

орнууд нь “хууль тогтоомжийн арга хэмжээг оролцуулан бүх зохистой арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй” байхаар Пактад зохицуулсан.

Улс орнууд нь газар, орон байрны эзэмшлийн аюулгүй байдлын хамгаалалт хангалтгүй хүмүүсийн хууль зүйн хамгаалалтыг нэмэгдүүлэх; орон байрны нөхцөл байдалд үр нөлөө бүхий дүн шинжилгээ хийх, ялангуяа орон гэргүй болон шаардлагад нийцэхгүй орон байрыг бүрэн, нарийвчлан тодорхойлох; албадан нүүлгэн шилжүүлэлтээс хамгаалах; шаардлагад нийцсэн орон байртай байх эрх зөрчигдсөн тохиолдолд үр нөлөөтэй хууль зүйн болон хөндөгдсөн эрхийг нөхөн сэргээх зохих арга хэмжээг авах зэрэг үйл ажиллагааг нэн даруй хэрэгжүүлэх үүрэгтэй хэмээн Эдийн засаг, нийгэм, соёлын Хороо тэмдэглэжээ.

### **Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг бодит амьдрал дээр дэвшилттэйгээр хэрэгжүүлэх нь**

Бүгд Найрамдах Доминикан улсын хүний эрхийн нөхцөл байдалтай холбогдуулан Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн Хороо “орон байртай байх эрхийг дэвшилттэйгээр хэрэгжүүлэхийн тулд Засгийн газар нь орон байрыг үндсэн үйлчилгээ (ус, цахилгаан, үерийн болон бохир ус зайлуулах болон эрүүл ахуйн байгууламж гэх мэт)-нд холбох, төрөөс олгох халамжийн зориулалттай нийтийн байранд орон байрны хэрэгцээ хамгийн их нийгмийн бүлгийг хамруулах зэргээр боломжит нөөцийг хамгийн дээд түвшинд байлгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх ёстой гэж онцлон тэмдэглэжээ. Мөн дээрх үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх баталгааг хангах үүрэгтэй. Хороотой харилцан зөвшилцсөний үндсэн дээр Засгийн газар нь тулгамдсан асуудлаа шийдвэрлэхдээ орон сууцны хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх явцад эрх ашиг нь хөндөгдөж, зөрчигдсөн хүмүүсийн оролцоог хангахад чиглэсэн санаачилгыг анхааралтай авч үзэх шаардлагатай. Үүнд: (а) хотыг хөгжүүлэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог дэмжих явдлыг албан ёсны болгох; (б) нөлөөлөлд өртөж буй газар нутгийн иргэдэд суурилсан иргэдийн байгууллагуудыг хууль зүйн хувьд хүлээн зөвшөөрөх; (в) нийгмийн хамгийн эмзэг буюу ядуу иргэдэд чиглэсэн зээлийн олон шугамыг нээх замаар нийтийн байрны санхүүжилтийн тогтолцоог бий болгох; (г) орон байрны салбарт орон нутгийн удирдлагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэх; (д) орон сууцны асуудал эрхэлсэн засгийн газрын байгууллагуудын хоорондын уялдаа холбоог сайжруулах, орон сууцны асуудал эрхэлсэн засгийн газрын тусдаа байгууллагыг бий болгоход анхаарах” зэрэг санаачлагууд байж болно. (Е/С.12/1994/20, 332–333 дугаар хуудас).

НҮБ-ын Дүрэм, Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал болон Хүүхдийн Эрхийн Конвенц зэрэг олон улсын баримт бичигт олон улсын тусалцаа, хамтын ажиллагааны үүргийн талаар тусгасан байдаг. Эдгээр нь дотоодын үүрэг хариуцлагыг орлохгүй хэдий ч хэрэв тухайн улс эдийн засаг, нийгэм, соёлын талаарх хүний эрхийг өөрөө бие даан хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд бусад улс орноос тусламж, дэмжлэг хүсч болно гэсэн үг. Энэ утгаараа олон улсын хамтын ажиллагаа нь бусад улс оронд тусламж, дэмжлэг үзүүлэх боломжтой улсуудад тусгайлан үүрэг хүлээлгэдэг.

Улс орнууд нь олон улсын тусламж, хамтын ажиллагааны талаар хэрэгжүүлэх хөтөлбөртэй байх бөгөөд бусад улс орныг шаардлагад нийцсэн орон байртай байх эрхтэй холбоотой үүргээ биелүүлэхэд нь зориулан эдийн засаг, техникийн тусламж үзүүлэх хэрэгтэй болдог. Олон улсын түвшинд хамтран ажиллах дээрх ерөнхий үүргийг Оролцогч улсуудын хүлээх үүргийн талаарх Хорооны Ерөнхий Зөвлөмж №3 (1990) болон Эрүүл мэндийн хамгийн дээд түвшинд хүрч болох эрхийн талаарх Ерөнхий Зөвлөмж №14 (2000)-д тус тус тусгасан байна.

## **Б. Үүргийн гурван төрөл**

Аливаа улс нь хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, биелүүлэх гэсэн үндсэн гурван төрлийн үүрэг хүлээдэг.

### Хүний эрхийг хүндэтгэх

Хүний эрхийг хүндэтгэх төрийн үүрэг нь иргэдийнхээ шаардлагад нийцсэн орон байртай байх эрхээ эдлэхэд нь шууд болон шууд бусаар нөлөөлөх, хөндлөнгөөс оролцох, саад болох аливаа үйлдлээс татгалзах, зайлсхийхийг хэлнэ.

Тухайлбал улс орнууд нь албадан нүүлгэн шилжүүлэх; орон байрыг эвдэн сүйтгэх; тодорхой бүлгийн эзэмшлийн аюулгүй байдлыг үгүйсгэх; орон байр, газар, бусад хөрөнгийг олж авах, эрхлэн удирдах зэрэгт эмэгтэйчүүдийн эрх, боломжийг хязгаарлах; орон байраа хамгаалах, халдашгүй байх эрхийг зөрчих; нийгмийн тодорхой бүлгийн орон байр, газар, эд хөрөнгөө нөхөн сэргээлгэх эрхийг үгүйсгэх; усны эх үүсвэрийг бохирдуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхээс татгалзах үүрэгтэй.

### Хүний эрхийг хамгаалах

Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг аливаа гуравдагч этгээдийн хууль бус үйлдлээс хамгаалах нь төрийн үндсэн үүрэг юм.

Улс орнууд нь газрын эзэн, хувийн өмчит барилгын компани гэх зэрэг гуравдагч этгээдүүд шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн талаарх холбогдох хүний эрхийн стандартыг дагаж мөрдөж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд хууль тогтоомж батлах болон шаардлагатай бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй. Төр, засгийн газар нь шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжихийн тулд орон сууцны болон түрээсийн зах зээлийн харилцааг зохицуулах; банк, санхүүгийн байгууллагууд орон сууцны санхүүжилтийг ялгаварлалгүй олгож байгааг баталгаажуулах; цэвэр ус, ариун цэвэр болон орон сууцтай холбоотой бусад үндсэн үйлчилгээг хүртэх боломж, хүртээмж, чанарт доголдол үүсэхгүй байх нөхцөлийг хангах; дээрх үйлчилгээг гуравдагч этгээдийн зүгээс хууль бусаар дур зоргоор тасалдуулахгүй байх; орон байр, газар, бусад хөрөнгийг олж авах, эрхлэн удирдах эрхэд сөргөөр нөлөөлж буй алагчлан харьцах явдлаас урьдчилан сэргийлэх, газар өмчлөгчдийн зүгээс нийгмийн тодорхой бүлгийг ялгаварлаж байгаа үйлдлийг хориглох; хувийн хэвшлийн байгууллагаас албадан нүүлгэн шилжүүлэлт явуулахгүй байх зэрэг баталгааг хангах үүрэгтэй.

### Хүний эрхийг биелүүлэх (хэрэгжүүлэх)

Төрөөс шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг бүрэн дүүрэн хангахад чиглэсэн хууль эрх зүйн, захиргааны, төсвийн, шүүхийн, соён гэгээрүүлэх гэх мэт бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тухайлбал, улс орнууд нь орон сууцны салбарын хөгжлийн зорилгыг тодорхойлсон, нийгмийн эмзэг бүлгийн эрх ашгийг тусгайлан авч үзсэн үндэсний орон сууцны бодлого, төлөвлөгөө батлах; тэдгээр зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг тодорхойлох; зорилгоо хэрэгжүүлэх хамгийн үр өгөөжтэй, хэмнэлттэй арга замыг тусгайлан заах; зайлшгүй хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцогч талуудын чиг үүрэг, гүйцэтгэх хугацааг тогтоох; үр дүнг нь хянах, дүн шинжилгээ хийх болон зөрчигдсөн эрхийг хамгаалах шаардлагатай арга хэрэгслийг бий болгох зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэгтэй.

Улс орнууд нь хүний эрхийг биелүүлэх чиг үүргийн хүрээнд өөрсдийн боломжит нөөцийг нэмэгдүүлэх замаар орон гэргүй болох явдлаас урьдчилан сэргийлэх; шаардлагад нийцсэн орон байрны шалгуурт нийцсэн дэд бүтцээр хангах (Үүнд: цахилгаан, ундны цэвэр ус, шаардлага хангасан ариун цэврийн байгууламж, хог хаягдал зайлуулах болон бусад шаардлагатай үйлчилгээний хүртээмжтэй бөгөөд үл ялгаварлах байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа багтана); эсхүл өөрсдөөс нь хамаарахгүй аливаа шалтгааны улмаас шаардлагад нийцсэн орон байртай байх эрхээ эдэлж чадахгүй байгаа хувь хүн болон нийгмийн тодорхой бүлэгт орон сууцны дэмжлэг үзүүлэх, бусад арга хэмжээ авах зэргээр иргэдийнхээ шаардлагад нийцсэн орон байраар хангагдах эрхийг дэвшилттэйгээр хэрэгжүүлнэ.

## **В. Бусад этгээдийн үүрэг**

Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хувийн хэвшлийн оролцогчид зөрчихгүй байх баталгааг хангах нь хүний эрхийг хамгаалах төрийн чиг үүрэгт хамаардаг. Энэ нь дээр дурдсан эрхүүдийг хамгаалах үүрэгтэй гэсэн үг. Нийгмийн бусад оролцогчид, тухайлбал иргэд, засгийн газар хоорондын болон төрийн бус байгууллага, бизнесийн байгууллагын зүгээс хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлд үүрэг хүлээх эсэх талаарх маргаан, мэтгэлцээн улам бүр нэмэгдсээр байна.

Энэ бүлэгт НҮБ-ын төрөлжсөн байгууллага болон хувийн хэвшлийн байгууллагын чиг үүргийг авч үзэх болно.

### *НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд*

НҮБ-ын Дүрэмд зааснаар хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хүндэтгэх нь түүний үндсэн зорилгын нэг юм. Хүний эрхийн олон улсын гэрээнүүдэд тэдгээрийг хэрэгжүүлэх НҮБ-ын байгууллагуудын чиг үүргийг мөн тусгасан байдаг.

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн Хорооноос гаргасан Олон улсын техникийн туслалцааны талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх Ерөнхий Зөвлөмж №2 (1990)-т олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны бүхий л үйл ажиллагаанд оролцож байгаа НҮБ-ын үндсэн болон төрөлжсөн байгууллагууд нь хөгжлийн төслийг хэрэгжүүлэх бүх үе шатанд Пактаар хамгаалагдсан эрхийг бүрэн дүүрэн хангах үүрэг хүлээнэ гэж тэмдэглэсэн.



## НҮБ-ын Хүм амын нутагшил, суурьшлын хөтөлбөр (НҮБ-Хабитат)

НҮБ-Хабитат бол хүн амын нутагшил, суурьшлын асуудал хариуцсан НҮБ-ын төрөлжсөн байгууллага юм. Хүн бүрийг шаардлагад нийцсэн орон байраар хангах зорилго бүхий нийгэм, хүрээлэн буй орчны хувьд тогтвортой хот, суурин газрыг дэмжих, сурталчлах нь уг байгууллагын чиг үүрэг юм. Энэхүү сорилт бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд НҮБ-Хабитатаас 2008-2013 онуудад Дунд хугацааны стратеги, Зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлж байна. Энэхүү төлөвлөгөө нь хүн амьдрах нөхцөл муу барилга, байшин болон газрыг дэд бүтэц, нийгмийн үйлчилгээнд холбох зэрэг шаардлагатай арга хэмжээ авах замаар ядуусын хорооллыг хөгжүүлэх, ядуурлаас урьдчилан сэргийлэх, цаашлаад тогтвортой хотжилтыг бий болгох зорилготой юм. Хүн амьдрах нөхцөл муу орон байр болон газрын асуудлыг онцгойлон авч үзэх нь дараах үндсэн үр дүнг бий болгоно.

- Оролцогч улс орнуудаас орон сууц, газар, эд хөрөнгийн эрхийг дэвшилттэйгээр хэрэгжүүлэх, ядуусын хорооллыг шинэчлэн сайжруулах, ядуурлаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн жендэрийн үр нөлөө бүхий бүх насныханд ээлтэй орон сууцны стратеги, эрх зүйн зохицуулалт бий болж, чадамж нэмэгдэнэ.
- Орон сууц, газар чөлөөлөлт болон хотын дэд бүтцийг хөгжүүлэх зорилготой гишүүддээ суурилсан олон нийтийн байгууллагууд бий болж, үйл ажиллагаа нь чадавхижина.
- Хотын ядуучууд болон хүн ам олноор суурьшсанаас эрх ашиг нь хөндөгдөж, зөрчигдөж байгаа хүмүүст онцгой анхаарал хандуулах замаар орон сууц, газар, хөрөнгийн хүртээмжийг сайжруулна.
- Гамшиг болон мөргөлдөөнд өртсөн бүс нутгуудад жендэрийн мэдрэмж бүхий орон сууцны хөтөлбөр, дахин орон сууцжуулах загваруудыг боловсруулж, хэрэгжүүлнэ.
- Эзэмшлийн аюулгүй байдал болон эмэгтэйчүүд, залуучуудын эрхийн хамгааллыг хэмжих арга хэрэгслийг сайжруулах, орон сууц, газар, эд хөрөнгийн эрхийг хэрэгжүүлэхэд чиглэсэн дэлхийн түвшний хяналт, үнэлгээний үр нөлөө бүхий механизмыг бий болгох, хөгжүүлэх замаар эзэмшлийн аюулгүй байдлыг хангах зорилгодоо хүрнэ.

НҮБ-Хабитатын үйл ажиллагаа нь НҮБ-ын Мянганы хөгжлийн Тунхаглал, ялангуяа Мянганы Хөгжлийн 7 дугаар Зорилгын 7 дугаар зорилтын г хэсэгт тодорхойлсон “2020 он гэхэд ядуусын хороололд амьдарч байгаа наанадаж 100 сая хүний амьдралын нөхцөлийг сайжруулах”, 7-ийн в хэсэгт заасан “2015 он гэхэд тогтвортой ундны цэвэр ус болон ариун цэврийн байгууламжаар хангагдаж чадахгүй байгаа хүмүүсийн тоог хоёр дахин багасгах” гэсэн зорилтуудтай шууд холбоотой.

Эх сурвалж: [www.unhabitat.org](http://www.unhabitat.org)

Сүүлийн жилүүдэд Ерөнхий Нарийн Бичгийн Даргын хэрэгжүүлж буй НҮБ-ын шинэчлэл (1997, 2002, 2012)-д хүний эрхийг хүндэтгэх талаарх НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, олон улсын санхүүгийн байгууллагуудын үүрэг, хариуцлагын чухлыг онцолсоор байна. Дэлхийн Банк болон Эдийн засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-аас албадан нүүлгэлттэй холбоотой хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох зорилгоор нүүлгэн шилжүүлэх болон дахин суурьшуулах үйл ажиллагаанд баримтлах удирдамжуудыг боловсруулжээ. 2003 онд НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд бүхий л хөгжлийн хөтөлбөр, тусламж дэмжлэг нь хүний эрхийг хэрэгжүүлэх, хүний эрхийн зарчим, хэм хэмжээнд үндэслэсэн байх шаардлагатай болохыг санал нэгтэйгээр баталгаажуулсан.

НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд нь орон байртай холбоотой хүний эрхийг хамгаалах чиглэлд ач холбогдол өгч ажиллах нь эрс нэмэгдэж байна. Үүний томоохон жишээ нь шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хэрэгжүүлэхэд Засгийн газар болон иргэний нийгмийн байгууллага, хүний эрхийг хамгаалах үндэсний байгууллагууд (ХЭҮБ)-ыг дэмжих зорилго бүхий НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссарын Газар (ХЭДКГ) болон НҮБ-Хабитатаас хамтран хэрэгжүүлж буй НҮБ-ын “Орон байртай байх Эрхийн Хөтөлбөр” юм.

### Хувийн хэвшил

Бизнес болон хувийн хэвшил нь чухал оролцогч юм. Учир нь үл хөдлөх хөрөнгийн төсөл хэрэгжүүлэгчид, барилгын болон дэд бүтцийн компаниуд зэрэг хувийн хэвшлийн байгууллагууд нь орон сууцны зах зээлийн харилцааны шууд оролцогчид бөгөөд барилга, орон сууцны менежмент, ашиглалтын хэвийн байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Дэлхийн олон улс оронд хувийн хэвшлийн байгууллагуудын хооронд хийгдэх үл хөдлөх эд хөрөнгийн түрээс болон худалдах, худалдан авах гэрээ зэрэг нь орон сууцны хэрэгцээний тодорхой хэсгийг хангадаг.

Үүний зэрэгцээ хувийн хэвшил нь шаардлагад нийцсэн орон байртай байх хүний эрхэд сөргөөр нөлөөлж байна. Томоохон далан барих болон бусад хөгжлийн төсөл, хөтөлбөрүүд, ялангуяа хий, газрын тос зэрэг байгалийн нөөцийг олборлох үйл ажиллагаа нь оршин суугчдыг нүүн шилжих болон байгаль орчны доройтолд хүргэх үндсэн шалтгаан болж байна. Газрын эзэн, хувийн өмчтөн, орон сууц болон үл хөдлөх

хөрөнгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага, этгээдүүд албадан нүүлгэлт хийх, түрээсийн харилцаанд нийгмийн тодорхой бүлгийг ялгаварлах зэргээр шаардлагад нийцсэн орон байртай байх эрхэд сөргөөр нөлөөлөх боломжтой байдаг.

Ажил олгогч ажилтныг орон байраар хангаж байгаа гэх мэт тохиолдолд хувийн хэвшил нь шаардлагад нийцсэн орон байртай байх эрхэд зохих байдлаар нөлөөлдөг байна. ОУХБ-ын Ажилтны орон байрны талаарх 1961 оны 115 дугаар Зөвлөмжид ажил олгогч ажилтныг орон байраар шууд хангах нь зохистой үйлдэл биш болохыг онцлон тэмдэглэжээ. Хэрэв ажил олгогч ажилтныг орон байраар хангах тохиолдолд тэрээр ажилтны эдэлбэл зохих хүний үндсэн эрхийг бүрэн хүлээн зөвшөөрөх бөгөөд түрээсийн төлбөр нь ажилтны орлогын түвшнээс өндөр, эсхүл ашиг олоход чиглэгдсэн байх ёсгүй. Түүнчлэн, байрны төлбөр болон нийгмийн бусад үйлчилгээг хөдөлмөрийн хөлс хэлбэрээр тооцохыг хориглох эсхүл ажилтнуудын эрх ашиг, сонирхлыг хамгаалах зорилгоор зохистой байдлаар зохицуулахыг дээрх зөвлөмжид тусгажээ.

Хүний эрхийг хүндэтгэдэг хувийн хэвшлийг бий болгох нь улс орнуудын үндсэн үүрэг хариуцлага хэдий ч хүний бүх эрх, тэр дундаа шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хүндэтгэх нь хувийн хэвшлийн байгууллагын хүлээх үүрэг хэмээн НҮБ-ын Ерөнхий Нарийн Бичгийн Даргын Бизнес ба Хүний эрхийн асуудал эрхэлсэн Тусгай төлөөлөгч хэлжээ. Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хүндэтгэх нь бизнес эрхлэгчдийн хувьд нийгмийн өмнө хүлээх үүрэг болно. Энэ үүрэг нь нийгмийн олон хэм хэмжээнд тусгалаа олсон байдаг. Олон улсын бизнесийн байгууллага, хувийн компаниуд хүртэл хүний эрхийг хүндэтгэх үүргээ биелүүлэхийг уриалсаар байна.

Бизнес болон хүний эрхийн чиглэлээр төрөл бүрийн сайн дурын санаачлага өрнөсөөр байна. Тухайлбал, НҮБ-ын Даян дэлхийн гэрээнд<sup>20</sup> хүний эрх, хөдөлмөрийн стандарт, байгаль орчин, авлигатай тэмцэх зэрэг хүний эрхийг хүндэтгэх тухай бизнесийн байгууллагуудын үүргийг тодорхойлжээ. Зарим компани бизнесийн үйл ажиллагаанд баримтлах хүний эрхийг хамгаалах өөрийн бодлого, хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэрэгслийг бий болгосон байна.

<sup>20</sup> <http://www.unglobalcompact.org>

## **IV. ШААРДЛАГАД НИЙЦСЭН ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ, УЛС ОРНУУДАД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА**

Улс орнууд шаардлагад нийцсэн орон байртай байх хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, биелүүлэх үүргээ хэрэгжүүлэхэд хариуцлагын механизм чухал ач холбогдолтой. Үндэсний, бүс нутгийн болон олон улсын түвшинд хяналт, шинжилгээ хийх үйл ажиллагаанд тухайн улс, иргэний нийгмийн байгууллага, үндэсний болон олон улсын хүний эрхийг хамгаалах механизм зэрэг олон оролцогч оролцдог.

### **A. Үндэсний түвшний хариуцлага, хяналт**

Хариуцлага нь улс орнуудыг шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хангах чиглэлээр ямар үйл ажиллагаа явуулсан, цаашид уг эрхийг үр нөлөөтэй, хурдан хугацаанд хэрэгжүүлэхийн тулд ямар ажлыг хэрхэн хийх арга хэрэгслийг тайлбарлахыг шаарддаг. Олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд дотоодын хариуцлага тооцох болон зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх механизмын талаар нарийвчлан тодорхойлоогүй хэдий ч энэ механизмын наад захын шаардлага нь хүрээмжтэй, ил тод, үр нөлөөтэй байх явдал юм.

#### *Захиргааны, бодлогын болон улс төрийн механизм*

Захиргааны болон улс төрийн механизм нь шүүхийн хариуцлагын механизмтай зэрэгцээ түвшинд, эсхүл түүний нэмэлт арга хэрэгсэл байдлаар хэрэгждэг. Тухайлбал, үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөвтэй уялдуулсан үндэсний орон сууцны бодлого, стратеги боловсруулах нь Засгийн газрын хариуцлагыг дээшлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Хүний эрхэд суурилсан шалгуур үзүүлэлт нь орон сууцны хөтөлбөрийн үндсэн үр дүн, үүнд хүрэх зарим үйл ажиллагаанд үр нөлөөтэй хяналт, шинжилгээ хийхэд чухал юм. Түүнчлэн, хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ зэрэг олон төрлийн үнэлгээ нь бодлого боловсруулагчдад хэрэгжүүлэхээр төлөвлөж буй бодлогынхоо үр дүнг урьдчилан тооцох, хожим нь шаардлагад нийцсэн орон байртай байх эрхэд тэр нь хэрхэн нөлөөлсөн талаарх бодит үр нөлөөг хянах боломжтой болгодог.

Ардчилсан үйл явц гэх мэт улс төрийн механизм, хөндлөнгийн этгээдийн хяналт, хамгаалалт нь хариуцлагын механизмыг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулсаар байдаг. Иргэний нийгмийн байгууллага нь шалгуур болон харьцуулсан үзүүлэлт гаргах, нөлөөллийн үнэлгээ, төсвийн дүн шинжилгээ хийх зэрэг хяналт, шинжилгээний олон арга хэрэгслийг ашиглаж, шаардлагад нийцсэн орон байртай байх эрхтэй холбоотой асуудлаар Засгийн газартай хариуцлага тооцох явдал улам бүр нэмэгдсээр байна. Тухайн улсын нөхцөл байдал, хэвшсэн ойлголтоос шалтгаалж, ялангуяа, үл ялгаварлан гадуурхах явдал (жишээ нь, хүйс)-ыг хэрэгжүүлж буй эсэхийг аль болох нарийвчлан, хүйсээр салгаж тодорхойлох боломжтой шалгуур үзүүлэлтүүд боловсруулах нь шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хэрхэн хангаж буй тухай чухал ач холбогдолтой мэдээлэл болно. НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын Газар (ХЭДКГ)-аас иргэний болон улс төрийн эрх, эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хэрэгжилтийг хөхиүлэн дэмжих, хяналт тавих шалгуур үзүүлэлтийг тодорхойлоход ашиглах концепц, арга зүйг боловсруулсан.

## **Хүний эрхийн шалгуур үзүүлэлтүүд**

НҮБ-ын ХЭДКГ-аас боловсруулсан Хүний эрхийн шалгуур үзүүлэлтийн хүрээ, түүний тогтоосон шалгуур үзүүлэлтүүд нь аливаа улс хүний эрхийн олон улсын хэм хэмжээ (зохион байгуулалтын буюу бүтцийн шалгуур үзүүлэлт)-г хүлээн зөвшөөрөх, тэдгээр хэм хэмжээнд заасан үүргээ биелүүлэхэд хүчин чармайлт гаргах (процессын шалгуур үзүүлэлт), түүнчлэн нөлөөлөлд өртсөн иргэдийн байр сууринаас тухайн хүчин чармайлтын үр дүнг авч үзэх (үр дүнгийн шалгуур үзүүлэлт) зэрэг хүлээсэн үүргээ шат дараатай биелүүлэх нь үйл ажиллагааны үнэлгээнд баримтлах урьдач шалгуур юм. Тухайлбал, шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг Үндсэн хуулиар хамгаалсан эсэх (зохион байгуулалтын буюу бүтцийн шалгуур үзүүлэлт); нийтийн буюу нийгмийн тодорхой бүлэгт зориулсан орон сууцны зардлын хувь хэмжээ (процессын шалгуур үзүүлэлтүүд); ядуусын хороололд амьдран суугаа болон албадан нүүлгэлтэд өртсөн хүмүүсийн хотын хүн амд эзлэх хувь хэмжээ (үр дүнгийн шалгуур үзүүлэлт) зэрэг нь шалгуур үзүүлэлтийн жишээ юм. Шалгуур үзүүлэлтүүдийг нийгмийн бүлэг болон ялгаварлан гадуурхалтад өртөх эрсдэл зэргээр салгаж, тодорхойлох нь ихээхэн ач холбогдолтой.

Энэ хүрээг НҮБ-ын ХЭДКГ-аас боловсруулахдаа олон улсын хүний эрхийг хамгаалах гэрээний байгууллагуудын хөндлөнгийн шинжээч, НҮБ-ын Тусгай илтгэгч, НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, хүний эрхийг хамгаалах үндэсний байгууллагууд, статистикийн болон, төрийн бус байгууллагууд гэх зэрэг үндэсний болон олон улсын хүний эрхийн холбогдох байгууллагуудтай олон тооны хурал, зөвлөлдөх уулзалт зохион байгуулсан. “Хүний эрхийн хэрэгжилтийг хөхиүлэн дэмжих, хяналт тавих шалгуур үзүүлэлтийн талаарх тайлан”-г дэлгэрүүлэн үзнэ үү (HRI/MC/2008/3). Орон байртай холбоотой дээрх баримт бичиг нь уг эрхийг дэвшилтэйгээр хэрэгжүүлэх дэлхийн түвшний хяналтын механизмыг бий болгох НҮБ-ын Орон байртай байх эрхийн Хөтөлбөрийн хэрэгжүүлсэн өмнөх санаачлагуудын үр дүнд үндэслэн билээ. НҮБ-ын Орон байртай байх эрхийн Хөтөлбөр, “Үйл ажиллагааны баримт бичиг No.2: Орон байртай байх эрхийн шалгуур үзүүлэлтүүд: Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг дэвшилтэйгээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг хэмжих нь”

### Шүүхийн механизм

Шүүхийн механизм нь үндэсний хэмжээнд хууль тогтоомжийг албадан хэрэгжүүлэх чухал бүрэлдэхүүн бөгөөд шаардлагад нийцсэн орон байртай байх эрх нь зөрчигдсөн иргэдийн эрхийг сэргээн эдлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Үндэсний хууль тогтоомжийн зохицуулалтыг шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн талаарх олон улсын баримт бичигтэй уялдуулах нь иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх явдлыг нэмэгдүүлэх, өргөжүүлэх боломжтой болгодог. Ингэснээр, шүүх эрх зүйн маргааныг шийдвэрлэхдээ Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт, Үндсэн хууль, шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хамгаалсан тухайлсан хууль болон уг эрхийн агуулгад хамаарах бусад эрхийн хамгаалалт зэргийг хэрэглэх боломжтой. Улс орнуудын үндэсний шүүхэд шүүхийн ийм практикийг хэрэглэх байдал нэмэгдсээр байна.

Өмнөд Африкийн Бүгд Найрамдах улсын Засгийн газар болон Грүтбүм болон бусад иргэний эсрэг маргааныг шийдвэрлэсэн **Өмнөд Африкийн Үндсэн хуулийн шүүхийг** жишээ болгож болно.

Хувийн орон сууцнаас нь нүүлгэн шилжүүлсний улмаас спортын талбайн ойролцоо хүнд нөхцөлд амьдарч байсан Грүтбүм эмэгтэй болон бусад иргэн өвлийн хүчтэй борооны улмаас түр хамгаалах байр нь шаардлагад нийцэхгүй болсон учир яаралтай арга хэмжээ авахыг шаардаж шүүхэд ханджээ. Шүүхээс үзэхдээ, хэдийгээр шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг дэвшилттэйгээр хэрэгжүүлэхэд чиглэсэн орон сууцны иж бүрэн хууль тогтоомж, бодлого байгаа хэдий ч эдгээр нь орон сууцны хүнд нөхцөлд амьдарч байгаа иргэдийн асуудлыг харгалзан үзээгүй гэжээ. Шүүхээс орон сууцны бодлогыг үндэслэл бүхий байх шалгуур үзүүлэлтийн дагуу нягтлан үзээд үндэсний орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсөв нь хүнд нөхцөлд аж төрж байгаа иргэдийг орхигдуулсан тул холбогдох шалгуур үзүүлэлтэд нийцэхгүй хэмээн үзжээ. Хэдийгээр Засгийн газар иргэдийн шаардсанаар тэднийг орон байраар нэн даруй хангах үүрэггүй ч хүнд нөхцөлд амьдарч байгаа иргэдэд дэмжлэг үзүүлэх үүрэгтэй болохыг шүүх шийдвэртээ онцолжээ. Түүнчлэн, орон байраар дэвшилттэйгээр хангах үүрэгт улс орнууд нэн даруй хэрэгжүүлэх арга хэмжээний төсөл, үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн нөөцийн асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй хэмээн шүүхээс тайлбарлажээ.

## **Хууль зүйн туслалцаа болон зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирол барагдуулах**

Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн зөрчилд ихэвчлэн хот, хөдөө орон нутагт амьдарч байгаа ядуу иргэд, үндэсний цөөнх, уугуул иргэд, албан бус цагаачид, дотоодын нүүн шилжигчид, эмэгтэйчүүд зэрэг ялгаварлан гадуурхалтад өртөх эрсдэлтэй, нийгмийн эмзэг бүлгийнхэн өртдөг. Хууль зүйн туслалцаа, үйлчилгээгээр хангах нь шаардлагад нийцсэн орон байртай байх эрх нь зөрчигдсөн иргэдийн эрхийг сэргээх, хохирлыг барагдуулах баталгааг хангадаг. Хэрэв хууль зүйн туслалцаа хомс бол эрх нь зөрчигдсөн иргэд шүүхийн зардлаа төлөх үү, эсхүл үр хүүхдүүдээ сургуульд сургах уу гэсэн сонголт хийхэд хүрдэг байна.

Шүүхийн эрх хамгааллыг хангахад үр нөлөө бүхий, хараат бус шүүх засаглал чухал үүрэгтэй. Шүүгчид болон хуульчид өөрсдийн албаны чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хараат бус байх бөгөөд аливаа нөлөөлөл, дарамт шахалт, хөндлөнгийн оролцооноос ангид байдлаар гагцхүү нөхцөл байдалд ач холбогдол өгч хууль тогтоомжийн дагуу асуудлыг шийдвэрлэх үүрэгтэй. Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгчид, хуульчид болон бусад эрх зүйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй мэргэжилтнүүд гүйцэтгэж буй чиг үүргээ сайтар ухамсарлан өөрсдийн хангалтгүй хэрэгжүүлсэн үйл ажиллагааныхаа төлөө хариуцлага хүлээдэг байх шаардлагатай.

### Хүний эрхийг хамгаалах үндэсний байгууллагууд

Хүний эрхийг хамгаалах үндэсний байгууллага нь Засгийн газарт зөвлөгөө өгөх, бодлого, хууль тогтоомжийн өөрчлөлтийн талаар санал хүсэлтээ илэрхийлэх, гомдол шийдвэрлэх, асуудлыг нягтлан шалгах, хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцийг соёрхон баталж хэрэгжилтийг хангах, иргэдийг соён гэгээрүүлэх, сургалт явуулах зэрэг үйл ажиллагаа явуулдаг.<sup>21</sup> Хүний эрхийг хамгаалах үндэсний байгууллагууд нь зарим тохиолдолд шүүхтэй ойролцоо үүрэг гүйцэтгэдэг бөгөөд хууль тогтоомжийг боловсронгуй болгох үйл ажиллагаанд оролцдог. Ихэнх хүний эрхийг хамгаалах үндэсний байгууллагуудыг комисс эсвэл омбудсмен гэж нэрлэдэг.

<sup>21</sup> Хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих үндэсний байгууллагуудын талаарх Ерөнхий Ассамблейн 48/134 тоот тогтоол ("Парисын Зарчмууд")-ийг харна уу.



## **Хүний эрхийн үндэсний комисс болон шаардлагад нийцсэн орон байртай байх эрх: зарим туршлага**

*Австрали улсын Хүний эрх, тэгш боломжийн Комисс нь нийгмийн тогтолцооны шинжтэй хүний эрхийн зөрчил, ялангуяа эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тулгамдсан асуудлыг амжилттай шийдвэрлэх туршлага бий болгожээ. Үүний нэг нь орон гэргүй хүүхдүүдийн эрхийн хамгааллын асуудал юм. Бидний Орон Гэргүй Хүүхдүүд: Орон гэргүй хүүхдийн талаарх үндэсний тайлан (1989)-д бичсэнээр Комиссын зүгээс Австралийн үндэсний болон мужийн Засгийн газар, хувийн хэвшлийн болон олон нийтийн байгууллагуудад хандан хэд хэдэн удаагийн нарийвчилсан зөвлөмж өгчээ. Эдгээр зөвлөмжид, “хүүхдийг үл хайхрах, хүчирхийлэх ноцтой үйлдлээс үүдэн хүүхдүүд орон гэрээ орхиж явах, эсхүл орон гэрээсээ гадуур амьдардаг байна. Хамтын нөхөрлөлийн орнууд нь Хүүхдийн Эрхийн Конвенцид заасны дагуу хүүхдийн нас, амьдралын нөхцөл зэргээс үл хамааран тэднийг дэмжих үүрэгтэй” хэмээн тэмдэглэжээ. Улмаар хүүхдүүд орон гэргүй байх нь хүний эрхийн асуудал бөгөөд хүүхдийн хэрэгцээ шаардлагыг тусгайлан авч үзсэн Засгийн газрын үйл ажиллагаа чухал болохыг олон нийтийн анхаарлын төвд авчирч чаджээ.*

*Кенийн Хүний эрхийн үндэсний Комисс нь эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хэрэгжилтийг хянах тусгай хөтөлбөртэй бөгөөд хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хүний эрхийн зөрчлийг шийдвэрлэх, холбогдох судалгаа явуулах, тайлан боловсруулах эрхтэй байдаг. Албадан нүүлгэлт, албан бус суурьшлын асуудалд тус Комисс анхааран ажилласаар иржээ. Дээрх чиг үүргийн хүрээнд холбогдох яамдууд болон орон сууцны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бусад байгууллагатай хамтран нүүлгэн шилжүүлэлтээс урьдчилан сэргийлэх, хохирол барагдуулах талаар үндэсний удирдамж боловсруулах чиглэлд ажилласаар байна.*

Зарим улс орнуудын хүний эрхийн үндэсний байгууллагууд эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хамгаалах чиглэлд ихээхэн анхаарал хандуулж байна. Энэ нь шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хамгаалахад ахиц дэвшил гаргахад нөлөөлнө.

Хүний эрхийн үндэсний байгууллагуудын хийж буй ажлын зэрэгцээ орон байртай холбоотой эрхийг бодитоор хэрэгжүүлэх, хамгаалах шинэ санаачлага, арга хэрэгслийг улс орнууд бий болгосоор байна.

### **Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн асуудал хариуцсан үндэсний Тусгай илтгэгч**

Бразил улс НҮБ-ын Тусгай илтгэгчийн тогтолцооноос санаа авч өөрийн улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Үндэсний Тусгай Илтгэгчдийг бий болгожээ. Эдгээр үндэсний илтгэгчийн нэг болох шаардлагад нийцсэн орон байртай байх эрх, хотын газартай холбоотой асуудал хариуцсан тусгай илтгэгч нь хүний эрхийн хүчирхийлэлтэй холбоотой иргэд, нийгмийн бүлгийн гаргасан гомдлыг хүлээн авах, хүний эрхийн зөрчлийг мөрдөн шалгахаар хэргийн газар ажилладаг байна. Түүнчлэн, тэрээр шаардлагад нийцсэн орон байртай байх эрхтэй холбоотой асуудлаар Бразил улсын Засгийн газарт зөвлөмж өгөх үүрэгтэй.

*Дэлгэрэнгүйг НҮБ-ын ХЭДКГ, Эдийн засаг, нийгэм, соёлын эрх: Хүний эрхийг хамгаалах үндэсний байгууллагын гарын авлага, Мэргэжлийн сургалтын бүрэлдэхүүн № 12 (НҮБ-ын хэвлэл, Худалдаанд гарсан дугаар E.04.XIV.8)*

### **Б. Бүс нутгийн түвшинд хүлээх хариуцлага**

Шаардлагад нийцсэн орон байртай байх хүний эрхийг бүс нутгийн шинжтэй хүний эрхийн гэрээ, конвенцоор хамгаалсан байдаг.

Хүний болон Ард түмний эрхийн Африкийн Комисс, Хүний эрхийн Америк хоорондын Комисс, Хүний эрхийн Америк хоорондын шүүх, Нийгмийн эрхийн Европын Хороо гэх зэрэг бүс нутгийн шинжтэй конвенцийн хэрэгжилтэд хяналт тавих байгууллага, шүүхийн байгууллагууд нь шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг хамгаалах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг.

**UIN.MN**  
СУДАЛГААНЫ САН

## **Итуанго Массакресийн гомдолтой Колумб улсад холбогдох маргаан**

Уг маргаан нь Колумб улсын Засгийн газраас хагас цэрэгжүүлсэн партизануудтай хамтран Итуанго хот (Ла Гранжа ба Эи Аро дүүрэг)-ын иргэдийг албадан нүүлгэж, орон байрыг нь эвдэн сүйтгэсэнтэй холбоотой юм. Албадан нүүлгэлтийн үед хүч албадлагыг хэтрүүлэн хэрэглэсэн зэрэг хүний эрхийн ноцтой зөрчил үйлдсэн гэсэн үндэслэлээр энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус 2 байгууллагын гомдлоор уг маргааныг үүсгэжээ.

Америк хоорондын шүүхээс дээрх маргааныг 2006 оны долдугаар сард шийдвэрлэхдээ албадан нүүлгэн шилжүүлэлт болон иргэдийн орон байрыг хүч хэрэглэн нураасан үйлдэл нь Хүний эрхийн Америкийн Конвенцийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг (орон байр нь хүч болон албадлага хэрэглэх явдлаас хамгаалагдсан байх эрх) болон 21 дүгээр зүйл (өмчлөх эрх)-ийг тус тус зөрчсөн болохыг тогтоожээ. Орон байрыг хүч хэрэглэн нураасан нь иргэдэд материаллаг хохирол учруулаад зогсохгүй тэдний нийгмийн оршин тогтнохуйд ноцтой нөлөөлж, иргэдийн орон байр, хувийн халдашгүй байдалд хууль бусаар ноцтой, зөвтгөх үндэслэлгүй, зэрлэг балмадаар хөндлөнгөөс халдаж байгаа болохыг онцлон тэмдэглэжээ.

Гишүүн улсууд нь хүний эрхийг хүндэтгэх, хөхиүлэн дэмжих үүргээ биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Хүний эрхийг хамгаалах Европын Комиссын Зөвлөлөөс нийгмийн тодорхой бүлгийг ялгаварлан гадуурхахтай холбоотой асуудлыг хөндөж, орон байртай байх эрхийг хэрэгжүүлэх чиглэлд анхааран ажиллаж байна.

## **В. Олон улсын түвшний хяналт**

### НҮБ-ын олон улсын гэрээний байгууллагууд

НҮБ-ын хүний эрхийн олон улсын гол баримт бичгүүдийн хэрэгжилтэд хяналт тавихад тухайлбал, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн Хороо гэх зэрэг бие даасан шинжээчдээс бүрдсэн олон улсын гэрээний байгууллагууд буюу Хороод тэргүүлэх үүрэг гүйцэтгэдэг. Эдгээр хороо нь оролцогч улсуудын тогтмол илгээх тайланд үндэслэн *ажиглалт, дүгнэлт* хийж, *ерөнхий зөвлөмж* гаргадаг.

Орон байртай байх эрхийн хэрэгжилтийн талаарх ажиглалт, дүгнэлтийг Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн Хорооноос гадна өөр

бусад хэд хэдэн хороо хийх эрхтэй байдаг. Тухайлбал, Хүний Эрхийн Хороо нь үл ялгаварлах зарчим, хувийн халдашгүй байдалд хууль бусаар хөндлөнгөөс халдсан гэх зэрэг хүрээнд шаардлагад нийцсэн орон байртай байх эрхэд анхаарал хандуулдаг.<sup>22</sup> Арьс үндсээр алагчлах үзлийг устгах Хорооноос шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх явцад нийгмийн цөөнхийг арьс үндсээр ялгаварлан гадуурхах тохиолдлууд гарсаар байгааг онцолжээ.<sup>23</sup> Харин Хүүхдийн Эрхийн Хороо нь шаардлагад нийцсэн орон байртай байх хүүхдийн эрхийн хүрээнд гудамжны болон нүүн шилжигч хүүхдүүдийн нөхцөл байдал зэрэг олон асуудлаар ажиллаж байна.<sup>24</sup> Эрүүдэн шүүхийн эсрэг Хороо албадан нүүлгэн шилжүүлэлт болон Цыган иргэдийг нүүлгэн суурьшуулах асуудалд анхаарал хандуулж, үүнтэй холбоотой хэд хэдэн зөвлөмж боловсруулжээ.<sup>25</sup>

Хүний Эрхийн Хороо, Эрүүдэн шүүхийн эсрэг Хороо, Арьс үндсээр алагчлах үзлийг устгах Хороо, Эмэгтэйчүүдийг алагчлах үзлийг устгах Хороо, Цагаач ажилчдын эрхийн Хороо, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн Хороо, Хүчээр сураггүй алга болгохтой тэмцэх Хороо (хараахан байгуулагдаагүй байгаа ) зэрэг нь хувь хүмүүсийн гомдол барагдуулах механизмтай байдаг. Үүний өмнө авч үзсэн зарим тохиолдолд Эрүүдэн шүүхийн эсрэг Хороо нь тухайлбал, “албадан нүүлгэн шилжүүлэлт нь хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэх үйлдэл мөн” гэж үзэж болохыг дэмжсэн байр суурийг илэрхийлж байсан.<sup>26</sup> 2008 оны 12 дугаар сард Ерөнхий Ассамблей Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пактын Нэмэлт Протоколыг баталсан. Энэ нь шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн зөрчилтэй холбоотой бүх асуудал, орон байрны харилцаанд ялгаварлан гадуурхагдсан талаар гомдол гаргах боломжийг бүрдүүлсэн. Нэмэлт Протокол нь түүнд 10 улс нэгдэн орсноор хүчин төгөлдөр болно.

<sup>22</sup> Жишээ болгон уншина уу. “Хүний Эрхийн Хорооны Ажиглалт, дүгнэлт: Португал улс” (CCPR/CO/78/PRT).

<sup>23</sup> “Арьс үндсээр алагчлах явдлыг устгах Хорооны Ажиглалт, дүгнэлт: Украин улс” (CERD/C/UKR/CO/18).

<sup>24</sup> “Хүүхдийн Эрхийн Хорооны ажиглалтын дүгнэлт: Колумб улс” (CRC/C/15/Add.137).

<sup>25</sup> Эрүүдэн шүүхийн эсрэг Хорооны дүгнэлт, зөвлөмж: Грек улс” (CAT/C/CR/33/2).

<sup>26</sup> Эрүүдэн шүүхийн эсрэг Хороо, шийдвэрийн дугаар No. 161/2000, Хажизи Дземажи болон бусад иргэний гомдолтой Серби болон Монтанегро зэрэг улсад холбогдох маргаан, 2002 оны 11 дүгээр сарын 21 (A/58/44).

Амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх эрхийн бүрэлдэхүүн хэсэг болох Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн асуудал хариуцсан НҮБ-ын Тусгай илтгэгч

“Тусгай журам” бол Хүний Эрхийн Хороо, Хүний эрхийн Зөвлөлөөс дэлхийн бүх улс орны хүний эрхийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор бий болгосон 2006 оны гуравдугаар сараас эхлэн хэрэгжсэн тусгай механизм юм. Хэдийгээр тэдний бүрэн эрх нь харилцан адилгүй ч ерөнхийдөө хянах шалгах, тухайлсан улс болон дэлхий дахиныг хамарсан асуудлаар хүний эрхийн нөхцөл байдлын тайлан боловсруулж гаргадаг.

Хорооны 2000/9 тоот тогтоолоор амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх эрхийн бүрэлдэхүүн хэсэг болох Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгчийн орон тоог бий болгосон. Харин Хүний эрхийн Зөвлөлийн 6/27 тоот тогтоолоор үл алагчлах асуудлыг амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх эрхийн бүрэлдэхүүн хэсэг болгож нэмж эрхлүүлэхээр шийдвэрлэсэн. Милүн Котари бол 2000 онд томилогдсон хамгийн анхны Тусгай илтгэгч бөгөөд түүний дараагаар 2008 онд Хүний Эрхийн Зөвлөлөөс Ракул Ролникийг тусгай илтгэгчээр томилсон.

#### **Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгчийн бүрэн эрх**

- Амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх эрхийн бүрэлдэхүүн хэсэг болох шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг бүрэн хэрэгжүүлэх явдлыг дэмжих
- Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийг бүрэн хэрэгжүүлэхэд тулгарч буй сорилт, хүндрэл бэрхшээл болон амжилттай шийдвэрлэсэн сайн туршлагуудыг олж тогтоох, уг эрхийг хамгаалахад үүсч буй хийдлийг тодорхойлох
- Бүрэн эрхийнхээ хүрээнд хариуцсан асуудлаар уг эрхийг хэрэгжүүлэхэд чиглэсэн практик шийдлүүдэд онцгой анхаарал хандуулах
- Орон байр болон газрын эрхийн харилцаанд хүйсийн онцлог шинжээс үүдэн эрх ашиг нь хөндөгдөж зөрчигдөх бүлгийг тодорхойлох зэргээр жендэрийн хандлагыг хэрэглэх
- Техникийн тусламж үзүүлэх асуудлаар дэмжлэг үзүүлэх

Тусгай илтгэгч нь чиг үүргээ хэрэгжүүлэхдээ зорилтод улс орнуудад айлчлах; хамаарал бүхий тулгамдсан асуудлыг нягтлан шалгах; шаардлагад нийцсэн орон байртай байх эрх нь зөрчигдсэн хувь хүн, нийгмийн бүлгээс ирүүлсэн гомдлыг хянах, үнэлэх мөн шаардлагатай тохиолдолд зөрчигдсэн эрхийн талаар Засгийн газрын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцох; Ерөнхий Ассамблей болон Хүний Эрхийн Зөвлөлд жил бүр тайлан хүргүүлэх зэргээр ажилладаг байна.

Тусгай илтгэгчийн зүгээс чиг үүргээ хэрэгжүүлэхдээ дараах асуудлыг чухалчлан үздэг. Үүнд: шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн агуулга, эрх зүйн байдал; орон гэргүй байдал, албадан нүүлгэн шилжүүлэлт; даяарчлал болон шаардлагад нийцсэн орон байртай байх эрх; ялгаварлан гадуурхалт болон орон байртай байх эрхийг хэрэгжүүлэх; шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох; шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн чухал бүрэлдэхүүн болох цэвэр ус, ариун цэврийн байгууламжаар хангагдах; шаардлагад нийцсэн орон байртай байх эмэгтэйчүүдийн эрх гэх зэрэг болно.

Тусгай илтгэгч хувь хүн, нийгмийн бүлгээс мэдээлэл хүлээн авч зохих байдлаар хариу хүргүүлдэг. Тусгай илтгэгчтэй дараах хаягаар харилцах боломжтой.

**НҮБ-ын Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч**

OHCHR-UNOG

8–14 avenue de la Paix

CH–1211 Geneva 10

Switzerland

E-mail: [urgent-action@ohchr.org](mailto:urgent-action@ohchr.org)

Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн асуудлыг бусад холбогдох асуудлаар бүрэн эрх олгогдсон Тусгай илтгэгчид анхаарал хандуулдаг.<sup>27</sup> Тэднээс хэд хэд нь өөрсдийн харьяалах асуудлын хүрээнд уг эрхийг хөнджээ.

<sup>27</sup> Тусгай илтгэгчид болон тэдний бүрэн эрхийн талаарх мэдээлэл, холбоо барих хаягийг сайтаас авна уу: <http://www.ohchr.org>.

### *Албадан нүүлгэлтийн асуудлаарх Зөвлөлдөх Бүлэг*

2004 онд НҮБ-Хабитатаас хууль бус нүүлгэн шилжүүлэлтэд хяналт тавих, зөвшилцөлд үндэслэсэн олон арга хувилбар бүхий нүүлгэн шилжүүлэлтийг тодорхойлох, хөхиүлэн дэмжих зорилгоор Албадан нүүлгэлтийн асуудлаарх Зөвлөлдөх бүлгийг байгуулсан. Энэхүү бүлэг нь үйл ажиллагаагаа НҮБ-Хабитатын Гүйцэтгэх Захиралд тайлагнах бөгөөд уг бүлэг нь засгийн газар хоорондын байгууллага, орон нутгийн удирдах байгууллага, төв засгийн газар, иргэний нийгмийн болон хөгжингүй болон хөгжиж буй улс орнуудын хөгжлийн асуудлаар мэргэшсэн шинжээчдээс бүрдэнэ.

Уг байгууллага нь үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш Аккра, Буэнос-Айрес, Куритиба (Бразил), Истанбул (Турк), Шинэ Орлеанс (АНУ), Порт Харкорт (Нигери), Ром болон Санто Доминго зэрэг улс орнуудад баримт, нотолгоонд үндэслэн асуудлыг судлах зорилгоор очиж ажиллажээ. Улмаар хэд хэдэн улс оронд өргөн хүрээг хамарсан албадан нүүлгэлт хийгдсээр байгаа тохиолдлуудыг баримтжуулж, асуудлыг шийдвэрлэх боломжит хувилбаруудыг харуулсан *Албадан нүүлгэлт - Шийдэл мөн үү? хэмээх* тайланг 2005, 2007 онд тус тус гаргажээ.<sup>28</sup>



<sup>28</sup> Дээрх хоёр тайланг <http://www.unhabitat.org/unhrp> сайтаас уншина уу.

## ХАВСРАЛТ

### ШААРДЛАГАД НИЙЦСЭН ОРОН БАЙРТАЙ БАЙХ ЭРХИЙН ТАЛААРХ ЗАРИМ ОЛОН УЛСЫН БАРИМТ БИЧИГ (ОН ЦАГИЙН ДАРААЛЛААР)

#### Олон улсын гэрээ, конвенц

НҮБ-ын Дүрэм (1945)

Дүрвэгчдийн эрх зүйн байдлын тухайн Конвенц (1951)

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пакт (1951)  
болон түүний Нэмэлт Протокол (2008)

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт (1966)  
болон түүний Нэмэлт Протоколууд (1966, 1999)

Арьс үндсээр алагчлах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын  
Конвенц (1965)

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу  
хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Конвенц  
(1984) болон түүний Нэмэлт Протокол (2002)

Тусгаар тогтносон улс орнууд дахь Уугуул иргэд болон омгийн  
хүмүүсийн эрхийг хамгаалах тухай ОУХБ-ын 169 дүгээр Конвенц  
(1989)

Хүүхдийн Эрхийн тухай Конвенц (1989) болон түүний нэмэлт хоёр  
Протокол (2000)

Цагаач ажилчид болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн эрхийг  
хамгаалах тухай олон улсын Конвенц (1990)

Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай Конвенц (1979)  
болон түүний нэмэлт Протокол (1999)

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенц (2006)  
болон түүний Нэмэлт Протокол (2006)

#### Бүс нутгийн гэрээ, конвенц

Хүний болон ард түмний эрхийн талаарх Африкийн Харти (1981)

Хүүхдийн эрх, нийгмийн хамгааллын талаарх Африкийн Харти  
(1990)

Хүний эрх болон үндсэн эрх чөлөөг хамгаалах Европын Конвенц  
(1950)

Европын Нийгмийн Харти (1961)

Цагаач ажилчдын эрх зүйн байдлын талаарх Европын Конвенц (1977)



Европын Нийгмийн Хартийн шинэчлэсэн найруулга (1996)  
Хүний эрхийн Америкийн конвенц (1969)

## **Олон улсын тунхаглал болон бусад баримт бичиг**

Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал (1948)  
Ахмад настны талаар баримтлах НҮБ-ын Зарчмууд, Ерөнхий  
Ассамблейн тогтоол 47/91 (1991)  
Дотоодын шилжилт хөдөлгөөний талаар баримтлах зарчмууд (1998)  
Ажилчдын орон байрны талаарх ОУХБ-ын 115 тоот зөвлөмж (1961)  
Уугуул иргэдийн эрхийн талаарх НҮБ-ын Тунхаглал, Ерөнхий  
Ассамблейн тогтоол 61/295 (2007)

## **Хүний эрхийн байгууллагын шинжээчдийн боловсруулсан удирдамж**

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн Хороо, Ерөнхий Зөвлөмж  
№3 (1990) Оролцогч улсуудын хүлээх үүргийн мөн чанарын талаар  
(E/1991/23)

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн Хороо, Ерөнхий Зөвлөмж  
№4 (1991) Шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн талаар  
(E/1992/23)

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн Хороо, Ерөнхий Зөвлөмж №5  
(1994) Хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар (E/1995/22)

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн Хороо, Ерөнхий Зөвлөмж  
№7 (1997) Шаардлагад нийцсэн орон байртай байх эрх: Албадан  
нүүлгэлт (E/1998/22, хавсралт IV)

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн Хороо, Ерөнхий Зөвлөмж №15  
(2002) Цэвэр усаар хангагдах эрх (E/C.12/2002/11)

Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах Хороо, Ерөнхий  
Зөвлөмж №19 (1992) Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн талаар  
(A/47/38)

Арьс үндсээр алагчлах бүх хэлбэрийг устгах Хороо, Ерөнхий  
Зөвлөмж №23 (1997) Уугуул иргэдийн эрхийн талаар (A/52/18,  
хавсралт V)

Дүрвэгсэд болон шилжин суурьшигчдын орон байр болон эд  
хөрөнгийг нөхөн сэргээх талаар баримтлах зарчим (E/CN.4/  
Sub.2/2005/17/Add.1)

Хөгжилд суурилсан нүүлгэлт болон шилжилт хөдөлгөөний талаар  
баримтлах Үндсэн зарчим, удирдамж (A/HRC/4/18, хавсралт I)

## **Хүний Эрхийн Хороо болон Хүний Эрхийн Зөвлөлийн тогтоол**

Амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх эрхийн бүрэлдэхүүн хэсэг болох шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн талаарх Хорооны 2000/9, 2001/28, 2002/21, 2003/27, 2004/21 тоот тогтоолууд

Албадан нүүлгэн шилжүүлэлтийн талаарх Хорооны 1993/77 тоот тогтоол Газар олж авах, түүнийг эрхлэн удирдах харилцаанд эмэгтэйчүүд эрх тэгш байдлаар өмчлөх эрхээ эдлэх, өөрийн хөрөнгө, шаардлагад нийцсэн орон байртай байх эрхээ тэгш байдлаар хэрэгжүүлэх эрхийн талаарх Хорооны 2000/13, 2001/34, 2002/49, 2003/22, 2004/21, 2005/25 тоот тогтоолууд

Амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх эрхийн бүрэлдэхүүн хэсэг болох шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн талаарх Зөвлөлийн 6/27 тоот тогтоол

## **Олон улсын хурлаас гаргасан баримт бичиг**

Хүм амын суурьшлын талаарх Истанбулын Тунхаглал (1996)

Хабитат Хөтөлбөр (1996)

НҮБ-ын Ерөнхий Ассамблей буюу “НҮБ-ын Мянганы Ассамблей”-н баталсан НҮБ-ын Мянганы Тунхаглал (2000)

Хүн амын суурьшлын талаарх Ванкувэрийн Тунхаглал (1976)

НҮБ-ын Хүрээлэн буй орчин ба хөгжлийн асуудлаар болсон бага хурлаас гаргасан Хүрээлэн буй орчин ба Хөгжлийн талаарх Риогийн Тунхаглал ба Хорин нэгдүгээр зууны мөрийн хөтөлбөр (1992)

Хүний эрхийн дэлхийн бага хурлаас баталсан Вэнийн Тунхаглал ба Үйл ажиллагааны хөтөлбөр (1993)

## **Цахим сайт**

### **Засгийн газар хоорондын байгууллагууд**

НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын Газар: [http:// www.ohchr.org](http://www.ohchr.org) (Энэхүү цахим сайт нь эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн талаарх ерөнхий мэдээлэл, эх сурвалжаас гадна хүний эрхийн олон улсын гэрээний байгууллагууд, амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх эрхийн бүрэлдэхүүн хэсэг болох шаардлагад нийцсэн орон байртай байх эрхийн асуудал хариуцсан Тусгай илтгэгчийн цахим хуудас гэх зэрэг тусгай журмын цахим хуудсуудтай.)

НҮБ-ын Хүм амын суурьшлын Хөтөлбөр (НҮБ-Хабитат): <http://www.unhabitat.org>

НҮБ-ын Орон байртай байх эрхийн талаарх Хөтөлбөр <http://www.unhabitat.org/unhrp>

НҮБ-Хабитатын Гүйцэтгэх захиралд тайлагнах үүрэгтэй Албадан нүүлгэн шилжүүлэлтийн талаарх Зөвлөлдөх Бүлэг (AGFE): <http://www.unhabitat.org/unhrp>

Хотын ядуу иргэдэд зориулсан орон сууц (НҮБ-ын Эдийн засаг болон Нийгмийн Хорооноос Ази, Номхон далайн улс орнуудад хэрэгжүүлсэн төсөл): <http://www.housing-the-urban-poor.net>

Европын Зөвлөлийн Хүний эрхийн асуудал хариуцсан комиссар: <http://www.coe.int/t/commissioner>

## **Олон улсын төрийн бус байгууллагууд**

Эмнести Интернэшнл: <http://www.amnesty.org>

Орон байрны эрхийн талаарх Азийн Эвсэл (ACHR): <http://www.achr.net>

Орон байрны эрх болон нүүлгэн шилжүүлэлтийн Төв (COHRE): <http://www.cohre.org>

Орон гэргүй хүмүүстэй ажилладаг Үндэсний байгууллагуудын

Европын Холбоо (FEANTSA): <http://www.feantsa.org>

Европын Цыган иргэдийн эрхийг хамгаалах төв (ERRC): <http://www.errc.org>

Хүнснийг нэгдүгээрт: мэдээлэл болон үйл ажиллагааны Сүлжээ (FIAN): <http://www.fian.org>

Хабитат Олон улсын Эвсэл (HIC): <http://www.hic-net.org>

Хөүмлөс Интернэшнл: <http://www.homeless-international.org>

Орон байр болон газрын эрхийн Сүлжээ (HLRN): <http://www.hlrn.org/english/home.asp>

Хүний эрхийн хяналт (Human rights watch-HRW): <http://www.hrw.org>

Олон улсын хуульчдын Комисс (ICJ): <http://www.icj.org>

Хүний Эрхийн Олон улсын Холбоо (FIDH): <http://www.fidh.org>

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын Сүлжээ (ESCRNet): <http://www.escr-net.org>

Түрээслэгчийн эрхийг хамгаалах олон улсын Холбоо (IUT): <http://www.iut.nu>

Слам Двэллэрс Интернэшнл (Slum Dwellers International-SDI): [www.sdinet.org](http://www.sdinet.org)

Нийгмийн хяналт: <http://www.socialwatch.org>

Эрүүдэн шүүхийн эсрэг Дэлхийн байгууллага (OMCT): <http://www.omct.org>

## Хүний Эрхийн Мэргэжлийн гарын авлага:<sup>29</sup>

- № 2 Хүний эрхийн олон улсын Билл (Товхимол 1)
- № 3 Хүний эрхийн салбарын Зөвлөх үйлчилгээ болон Техникийн Хамтын Ажиллагаа (Товхимол 1)
- № 4 Эрүүдэн шүүхтэй тэмцэх нь (Товхимол 1)
- № 6 Хүчээр эсхүл сайн дурын бус үндсэн дээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах нь (Товхимол 3)
- № 7 Гомдол гаргах журам (Товхимол 1)
- № 9 Уугуул иргэдийн эрх (Товхимол 1)
- № 10 Хүүхдийн эрх (Товхимол 1)
- № 11 Шүүхээс гадуур, хууль бусаар цаазын ялыг хэрэглэх нь (Товхимол 1)
- № 12 Арьс үндсээр алагчлахыг устгах Хороо
- № 13 Олон улсын Хүмүүнлэгийн эрх зүй ба Хүний эрх
- № 14 Орчин үеийн боолчлолын хэлбэрүүд
- № 15 Иргэний болон улс төрийн эрх: Хүний Эрхийн Хороо (Товхимол 1)
- № 16 Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн Хороо (Товхимол 1)
- № 17 Эрүүдэн шүүхийн эсрэг Хороо
- № 18 Цөөнхийн эрх (Товхимол 1)
- № 19 Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах Үндэсний Байгууллагууд
- № 20 Дүрвэгсэд ба хүний эрх
- № 21 Шаардлагад нийцсэн орон байраар хангагдах эрх (Товхимол 1)
- № 22 Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах нь: Конвенц болон Хороо
- № 23 Эмэгтэйчүүд, хүүхдүүдийн эрүүл мэндэд хор хөнөөлтэй уламжлалт дадал заншлууд
- № 24 Цагаач ажилчдын талаарх олон улсын Конвенц ба түүний Хороо (Товхимол 1)
- № 25 Албадан нүүлгэлт ба Хүний эрх
- № 26 Дур зоргоор хорихтой тэмцэх Ажлын Хэсэг
- № 27 НҮБ-ын Тусгай илтгэгчдийн талаарх 17 түгээмэл асуулт

<sup>29</sup> Мэргэжлийн гарын авлага 1, 5, 8-ыг ашиглах боломжгүй. Бусад мэргэжлийн гарын авлагыг <http://www.ohchr.org> сайтаас харах боломжтой.

- № 28 Бизнесийн хэт ашгийн төлөөх үйл ажиллагаа нь өөрийгөө тодорхойлох хүний эрхэд нөлөөлөх нь
- № 29 Хүний эрхийг хамгаалагчид: Хүний эрхийг хамгаалагчдын эрхийг хамгаалах нь
- № 30 НҮБ-ын хүний эрхийн олон улсын гэрээний байгууллагуудын тогтолцоо - Хүний эрхийн тулгуур баримт бичиг болон олон улсын гэрээний байгууллагуудын танилцуулга
- № 31 Эрүүл мэндээ хамгаалах эрх
- № 32 Хүний эрх, Терроризм, Терроризмтой тэмцэх нь
- № 33 Эдийн засаг, нийгэм, соёлын эрхтэй холбоотой түгээмэл асуултууд

*Хүний эрхийн асуудлаар цуврал болгон хэвлэдэг мэргэжлийн гарын авлагыг* Женев хотод байрлах НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын газраас эрхлэн гаргадаг. Уг цувралд чухалчлан авч үзэх шаардлагатай хүний эрхийн болон тусгай ашиг сонирхолтой холбоотой асуудлуудыг түүвэрлэн тухайлсан байдлаар авч үздэг.

*Хүний Эрхийн асуудлаарх Мэргэжлийн гарын авлага* нь уншигчдын хүний эрхийн талаарх үндсэн ойлголт, НҮБ-аас хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих зорилгоор ямар үйл ажиллагаа явуулж байгаа, хүний эрхийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх боломжтой олон улсын механизмыг хэрхэн ашиглах зэрэг ойлголтыг өгдөг. *Хүний Эрхийн асуудлаарх Мэргэжлийн гарын авлагыг* дэлхийн өнцөг булан бүрт үнэ төлбөргүй түгээдэг. Уг баримтын агуулгад ямар нэг өөрчлөлт оруулахгүй байх нөхцөлтэйгөөр НҮБ-ын албан ёсны хэлнээс бусад хэл рүү хөрвүүлэн хэвлэхийг зөвшөөрөх бөгөөд Женев хотод байрлах НҮБ-ын Хүний Эрхийн Дээд Комиссарын Газарт мэдэгдэж, тухайн баримтын эх үүсвэр нь тус байгууллага болохыг заавал тэмдэглэсэн байна.



Дараах хаягаар санал хүсэлтээ илгээнэ үү:

---

Office of the United Nations High Commissioner for Human Rights  
United Nations Office at Geneva 8–14,  
Avenue de la Paix  
CH–1211 Geneva 10 Switzerland

New York Office: Office of the United Nations High Commissioner for Human Rights  
United Nations New York, NY 10017  
United States of America

---

Женев хот, НҮБ-д 2009 оны 11 дүгээр сард хэвлэв. ISSN 1014-5567  
GE.09-14883–November 2009–9,245  
Женев хот, НҮБ-д 2014 оны 5 дугаар сард дахин хэвлэв.  
GE.14-80125-May 2014-2,000

# Хүний Эрх



ОИХМН  
СЭТЭЛГ ААНЫ САН